

# АЗИД ЛГБТ БАЙХ НЬ: МОНГОЛ УЛСЫН ТАЙЛАН

ЛЕСБИАН, ГЕЙ, БИСЕКСУАЛ, ТРАНСЖЕНДЭР (ЛГБТ) ХҮМҮҮС,  
ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, НИЙГМИЙН ОРЧНЫ  
ОРОЛЦООНД СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ



**USAID**  
FROM THE AMERICAN PEOPLE



*Empowered lives.  
Resilient nations.*

НҮБХХ, АНУ-ын ОУХА (2014) Азид ЛГБТ байх нь: Монгол Улсын тайлан

Энэхүү тайланг 'Азид ЛГБТ байх нь' санаачлагын хүрээнд НҮБХХ, АНУ-ын ОУХА-аас хянан үзсэн болно. Уг тайланг 2014 оны 3 дугаар сард Улаанбаатарт болсон Монголын ЛГБТ Үндэсний хэлэлцүүлгийн дүн, оролцогчидтой хийсэн ярилцлага, хэвлэгдсэн судалгаануудад үндэслэн бэлтгэв. Тайлан дахь байр суурь, үзэл бодол нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй болно.

НҮБХХ нь улс үндэстнүүд хямралыг сөрөн гэтэлж, хүн бүрийн амьдралын чанарыг дээшлүүлэхүйц өсөлтийн төлөө түүштай замнахад нь дэм болохын тулд нийгмийн бүхий л хүрээний хүмүүстэй түншлэн ажилладаг. Дэлхийн 170 гаруй улс орон, газар нутагт хүрч ажиллахдаа дэлхийн нийтийн чиг хандлага, орон нутгийн нөхцөл байдлын талаарх мэдлэг ойлголтдоо тулгуурлан, олон түмэн эрх мэдэлтэй байж, улс үндэстнүүд цуцалтгүй хөгжихөд дэмжлэг үзүүлэхийг зорьдог.

Зохиогчийн эрх НҮБХХ-т хадгалагдана, 2014

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр  
НҮБХХ Ази номхон далайн бүсийн төв  
НҮБ-ын үйлчилгээний байр, 3 дугаар давхар  
Раждамнэрн Нок өргөн чөлөө, Бангкок 10200, Тайланд  
Цахим шуудан: [aprc.th@undp.org](mailto:aprc.th@undp.org)  
Утас: +66 (0)2 304-9100  
Факс: +66 (0)2 280-2700  
Цахим хуудас: <http://asia-pacific.undp.org/>

# АЗИД ЛГБТ БАЙХ НЬ: МОНГОЛ УЛСЫН ТАЙЛАН

ЛЕСБИАН, ГЕЙ, БИСЕКСУАЛ, ТРАНСЖЕНДЭР (ЛГБТ) ХҮМҮҮС,  
ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, НИЙГМИЙН ОРЧНЫ  
ОРОЛЦООНД СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ



*Empowered lives.  
Resilient nations.*

# ГАРЧИГ

ТАЛАРХАЛ .....	5
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ.....	6
ХУРААНГУЙ .....	7

---

<b>УДИРТГАЛ.....</b>	<b>14</b>
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ЛГБТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ .....	15
Азид ЛГБТ байх нь .....	17

<b>ЛГБТ МОНГОЛЧУУДЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТОЙМ .....</b>	<b>18</b>
Монгол дахь ЛГБТ асуудлын түүхэн хөгжил ба өрнөл .....	18
Монгол улс ба олон улсын хүний эрхийн механизм.....	20
Монголын ЛГБТ асуудлаарх хууль эрх зүйн орчин.....	21
Бүтэц тогтолцооны орчин .....	23
Соёл ба нийгмийн орчин .....	25

<b>ЛГБТ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ НЬ .....</b>	<b>27</b>
Хөдөлмөр эрхлэлт.....	27
Боловсрол .....	30
Эрүүл мэнд.....	32
Гэр бүл .....	34
Хэвлэл мэдээлэл .....	37
ЛГБТ олон нийтийн хөгжил .....	39

<b>ЛГБТ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАДАВХИ .....</b>	<b>40</b>
---	-----------

---

<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....</b>	<b>43</b>
--------------------------------	-----------

ХАВСРАЛТ 1: Монгол дахь ЛГБТ байгууллагуудын жагсаалт.....	46
ХАВСРАЛТ 2: Монголын ЛГБТ Үндэсний хэлэлцүүлэгт оролцсон байгууллагуудын жагсаалт .....	47

# ТАЛАРХАЛ

Монголын ЛГБТ Үндэсний хэлэлцүүлэг болон энэхүү тайланг бэлтгэхэд НҮБХХ, АНУ-ын ОУХА-аас “Азид ЛГБТ байх нь” санаачлагын хүрээнд дэмжлэг үзүүлэв. Тус тайланд 2014 оны 3 дугаар сарын 20-21-нд Улаанбаатар хотноо НҮБ-ын байранд болсон Монголын ЛГБТ Үндэсний хэлэлцүүлгийн дүнг тусгав. Мөн оролцогчидтой ярилцлага хийх, нийтлэгдсэн баримтуудыг судлах зэргээр зарим нэмэлт мэдээлэл цуглуулж ашиглав.

Тус тайлан хэвлэгдэн гарах үед ЛГБТ олон нийтийн нөлөөллийн болон бусад ажлын явц, өрнөлөөс шалтгаалан сүүлийн үеийн зарим үйл явдал багтаагүй байх талтай. Хэлэлцүүлгийг зохион байгуулагчдын зүгээс хэлэлцүүлэгт оролцсон ЛГБТ олон нийтийн бүх төлөөлөгч, энэ тайланг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан бүх хүнд гүн талархал илэрхийлье. Оролцсон байгууллагуудын жагсаалтыг Хавсралт 2-т харуулав.

Энэхүү тайланг Д. Магнайсүрэн (НҮБ-ын Сайн дурынхны хөтөлбөр), Л. Бархас (НҮБХХ), Эвелин Рудники (НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөр), Д. Алтанчимэг (НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөр) нарын бүрэлдхүүнтэй баг бэлтгэв. Тайланг бэлтгэх явцад ЛГБТ олон нийттэй зөвлөлдөн хамтран ажилласан бөгөөд дараахь хүмүүс үнэтэй санал, зөвлөгөө өгч, хувь оруулсныг цохон тэмдэглэе. Үүнд Н. Анараа (ЛГБТ Төвийн гүйцэтгэх захирал), А. Балдангомбо (ЛГБТ Төвийн хуулийн ажилтан байсан), Д. Мягмардорж (Залуус эрүүл мэнд ТББ-ын гүйцэтгэх захирал), Г. Эрдэнэтуяа (Хамтдаа Төвийн гүйцэтгэх захирал), Н. Батзориг (Шинэ өөдрөг амьдрал ТББ-ын гүйцэтгэх захирал), Б. Гансүх (ЭМЯ-ны Глобаль сангийн төслийн ажилтан), А. Булбул (ХӨСҮТ-ийн халдвар судлагч), Ж. Нямпүрэв, Ж. Наранбаатар (Хамтдаа төв), Д. Мөнхнасан, Г. Чинзориг (Залуус эрүүл мэнд), С. Батзориг, Д. Мөнхтуяа (ЛГБТ Төв).

Зохион байгуулагчдын зүгээс хэлэлцүүлгийг зохион байгуулахад гүн туслалцаа үзүүлсэн Сезин Синанолу (НҮБ-ын Суурин зохицуулагч, НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч), Томас Эрикссон (НҮБХХ-ийн Орлогч суурин төлөөлөгч), Л. Бархас (НҮБХХ-ийн ажилтан), П. Жаргалсайхан (НҮБХХ-ийн олон нийттэй харилцах ажилтан), НҮБХХ-ийн захиргаа, санхүүгийн баг, Д. Алтанчимэг (НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөр), Н. Доржханд (НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөрийн төслийн ажилтан), Эвелин Рудники (НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөр), Саурав Жун Тапа (НҮБХХ-ийн АНДБТ-ийн ЛГБТ, хүний эрхийн асуудал хариуцсан ажилтан) нарт талархал илэрхийлье. Мөн Хэлэлцүүлгийг чадварлагаар идэвхжүүлэн ажилласан Д. Мягмардорж, илтгэгч Г. Нямпүрэв, В. Эгшиглэн, Г. Чинзориг, Г. Эрдэнэтуяа, Т. Мөнхжаргал, А. Балдангомбо, Б. Билгүүнсайхан, хэлэлцүүлгийн ерөнхий үйл явцыг хүчин чармайлт гарган чадварлаг зохион байгуулсан Д. Магнайсүрэн (НҮБ-ын Сайн дурынхны хөтөлбөр) нарт талархал илэрхийлье.

АНУ-ын ОУХА-ийн Ази дахь бүсийн хөгжлийн газар (АБХГ)-ын Засаглал ба эмзэг хүн амын асуудал эрхэлсэн албаны Орлогч захирал Томас Вайт; Америкийн Шинжлэх ухаан, технологийн дэвшлийн нийгэмлэгийн гишүүн Ви Лам; НҮБХХ-ийн АНБТ-ийн бодлогын зөвлөх Эдмунд Сэттл, мөн ЛГБТ, хүний эрхийн асуудал хариуцсан ажилтан Саурав Жун Тапа, НҮБХХ-ийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газрын Засаглалын багийн ахлагч Ц. Даваадулам нар тайланг хянаж, үнэтэй санал зөвлөгөө өгсөн болно. НҮБ-ын суурин зохицуулагч, НҮБХХ-ийн суурин төлөөлөгч Сезин Синанолу мөн тайланг уншиж танилцсан. Энди Кван хянан тохиолдуулав.

Тайланд НҮБХХ-ийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газраас авсан Монголын ЛГБТ Үндэсний хэлэлцүүлгийн зургуудыг ашиглав. Тайланг орчуулж, хэвлүүлэхэд НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөрөөс Европын Холбооны дэмжлэгтэй хэрэгжиж буй төслийн хүрээнд туслалцаа үзүүлэв.

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АНБТ	Ази Номхон далайн бүсийн төв
АНУ-ын ОУХА	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
БЧБХБИ	Бэлгийн чиг баримжаа ба хүйсийн баримжаа илэрхийлэл
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЛГБТ	Лесбиан, Гей, Бисексуал болон Трансжендэр
ИУТЭОУП	Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пакт
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
НҮБ-ын СДХ	НҮБ-ын Сайн дурынхны хөтөлбөр
НҮБХАС	НҮБ-ын Хүн амын сан
НҮБХС	НҮБ-ын Хүүхдийн сан
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
НҮБ-ын ХЭДКГ	НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарын газар
СДЗШ	Сайн дурын зөвлөгөө шинжилгээ
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХДХВ	Хүний дархлал хомсдлын вирус
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХЭЗ	Хүний эрхийн зөвлөл
ХЭТБЭНХ	Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭЗНСЭОУП	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт
ЭБЭ	Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд
ЭЯГБХУК	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах конвенц
ЭШЭК	Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц



# ХУРААНГУЙ



Нийт оролцогчид

## УДИРТГАЛ

Энхүү тайланд Монголын лесбиян, гей, бисексуал, трансжендэр (ЛГБТ) хүмүүст тулгарч буй хууль эрх зүй, нийгмийн орчны асуудлыг авч үзэв. Уг тайланг 2014 оны 3 сарын 20-21-нд Улаанбаатарт болсон Монголын ЛГБТ Үндэсний хэлэлцүүлгийн үр дүн, мөн оролцогчидтой хийсэн ярилцлага, хэвлэгдсэн судалгаанд үндэслэн бэлтгэв. Үндэсний хэлэлцүүлэгт ЛГБТ олон нийт, идэвхтэн, иргэний нийгмийн байгууллага, хүний эрхийн мэргэжилтэн, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Монгол Улсын төрийн байгууллага, хөгжлийн түнш байгууллагуудыг төлөөлсөн нийт 140 хүн оролцсон юм.

Үндэсний хэлэлцүүлгийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс (НҮБХХ) АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагтай (АНУ-ын ОУХА) хамтран зохион байгуулсан. Уг арга хэмжээ нь “Азид ЛГБТ байх нь: Лесбиян, Гей, Бисексуал, Трансжендэр (ЛГБТ) хүмүүс, иргэний нийгмийн хууль эрх зүй, нийгмийн орчны оролцоонд суурилсан үнэлгээ, шинжилгээ” хэмээх өргөн хүрээтэй санаачлагын нэг хэсэг юм. “Азид ЛГБТ байх нь” хэмээх уг санаачлага нь 2012 оны 12 сарын 10 буюу Хүний эрхийн өдөр нээлтээ хийж, Азийн ЛГБТ олон нийтэд түшиглэсэн байгууллага, олон нийтийн манлайлагчид болон НҮБХХ, АНУ-ын ОУХА хамтран Ази даяар явуулсан анхны томоохон арга хэмжээ юм. Уг арга хэмжээний хүрээнд Камбож, Хятад, Индонези, Монгол, Балба, Филиппин, Тайланд, Вьетнам гэсэн Азийн найман орон дахь ЛГБТ хүмүүсийн нөхцөл байдлыг хөгжлийн болон хүний эрхийн өнцгөөс авч үзэж байгаа юм.

“Азид ЛГБТ байх нь” санаачлага нь бүс нутаг дахь ЛГБТ хүмүүсийн сүлжээг дэмжих, суурь мэдээлэл бий болгох, ЛГБТ олон нийтийн байгууллагуудын бодлогын хэлэлцүүлэгт оролцох, олон нийтийг дайчлах чадавхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой. Уг санаачлагаар дамжуулан ЛГБТ хүмүүсийн хүний төрөлх эрхийн тухай, бүс нутгийн хэмжээнд амь бөхтэй оршоор буй гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах үзэгдлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийг зорив. Мөн энэ тайлан гэх мэт судалгаа, хэвлэл мэдээллийн бүтээгдхүүнийг боловсруулах замаар НҮБХХ, НҮБ-ын бусад байгууллага; АНУ-ын ОУХА, АНУ-

ын Засгийн газар; хөгжлийн бусад түншийн хөгжлийн төлөөх үйл ажиллагаанд ЛГБТ хүмүүсийн оролцоог хангахад түлхэц болохыг зорьсон юм. Эцэст нь, энэхүү санаачлага нь олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр гарсан ЛГБТ хүмүүсийн санаа бодлыг тусгах замаар Азид ЛГБТ хүмүүсийн хүний эрхийг дэмжих чиглэлээр ажиллаж буй талуудыг холбоход дэм болж байгаа юм.

## Монгол дахь ЛГБТ ба өрнөл

Саяхныг хүртэл ижил хүйсийн хүмүүсийн бэлгийн харилцаа буюу уламжлалт бус бэлгийн чиг баримжаа ба хүйсийн баримжаа илэрхийллийг (БЧБХБИ) илтгэсэн үг хэллэг Монгол хэлэнд байдаггүй байв. 20 дугаар зуунаас өмнө Монголд ЛГБТ хүмүүст хэрхэн ханддаг байсан тухай баримт сэлт маш ховор. 1924 онд социалист систем тогтсоноос хойш 1990-ээд оныг хүртэлх хугацаанд ч ЛГБТ хүмүүсийн тухай материал нийтлэгдэж байсангүй. Энэ талаар ил чөлөөтэй ярьдаггүй байсан учраас ижил хүйсийн хүмүүсийн бэлгийн харилцаатай холбоотой асуудал нууцлаг хаалттай сэдэв байсаар иржээ. Гагцхүү 1992 оны ардчилсан Үндсэн хууль батлагдсанаар Монголын нийгэмд ижил хүйсийн хүмүүсийн бэлгийн харьцаа, уламжлалт бус хүйсийн баримжаа илэрхийллийн асуудлыг олон талаас хөндөн ярих боломжтой болж, яриа хэлэлцүүлгийн хүлээн зөвшөөрөгдсөн сэдэв болсон билээ. Монголын ЛГБТ асуудлаарх яриа хэлэлцүүлэг харьцангуй шинэ бөгөөд нийслэл Улаанбаатарт л голдуу явагдаж байна.

Өнөөг хүртэл бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн янз бүрийн хэлбэрийг Монголд хэрхэн авч үзэж ирсэн талаар нийтлэгдсэн материал байхгүй байгаа нь тус орны хувьд энэ сэдэв саяхнаас л олон нийтийн дунд яригдах болсныг илтгэж байна.

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталж, ардчилсан нийгэмд шилжин орсноор хүний эрхийн асуудал өргөн хүрээнд яригдах болсон. Хүн бүр хуулийн өмнө адил тэгш байх, хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан. 1997 оны 1 дүгээр сард Төрийн бус байгууллагын тухай хууль батлагдаж, 1999 онд “Тавилан” гэдэг гей эрэгтэйчүүдэд үйлчлэх анхны төрийн бус байгууллага үүсэн байгуулагджээ. Бусад олон орны нэгэн адил 2000-аад оны эхэн үед ЛГБТ хүмүүсийн эрхийн асуудал нь эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдэд (ЭБЭ) хандсан эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаатай нягт холбогдож байсан ба хэд хэдэн ТББ эрх хамгаалал ба эрүүл мэндийг дэмжих хос зорилготой байгуулагдаж байсан билээ. ЛГБТ хүний эрх, нөлөөлөл сурталчилгааны чиглэлээр ажилладаг анхны байгууллага болох ЛГБТ Төв 2007 онд байгуулагдсан ч захиргааны журамтай холбоотой бэрхшээлээс шалтгаалан 2009 онд л албан ёсоор бүртгэгдсэн байна. 2013 онд ЛГБТ олон нийт Монголд анх удаа “Бахархлын долоо хоног” хэмээх арга хэмжээг зохион байгуулжээ.

## ҮР ДҮН

Энэ тайланд Монгол дахь ЛГБТ хүмүүсийн эрхийн нөхцөл байдал, түүнчлэн хууль эрх зүй, бүтэц тогтолцоо, соёл, нийгмийн орчинд ЛГБТ олон нийтэд тулгарч буй асуудлыг танилцуулна. Мөн олон улсын хүний эрхийг хамгаалах механизм ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалахад гүйцэтгэж буй үүргийн талаар дурдах болно. Өдөр тутмын амьдралд тулгарч буй асуудлыг хөдөлмөр эрхлэлт, боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, хэвлэл мэдээлэл гэсэн чиглэлээр авч үзэв. Эцэст нь, Монголын ЛГБТ олон нийтийн хөгжил, ЛГБТ асуудлаар ажилладаг байгууллагуудын чадавхийн талаар авч үзэв.

Монгол дахь ЛГБТ хүмүүсийн эрхийн талаарх тойм:

- **Хууль эрх зүйн орчин:** Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээр (БЧБХБИ) шууд ялгаварлан гадуурхсан заалт байхгүй. Гэхдээ нийгмийн өөрчлөлт шинэчлэлтэй холбоотойгоор ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалахад эрх зүйн тодорхой шинэчлэл шаардагдаж байгаа билээ. Энэ чиглэлд зарим ахиц ч гарч байна. 2009 оны



6 дугаар сард Иргэний бүртгэлийн тухай хуулийн 20 (1) дэхь заалтад эмнэлгийн магадлагааг үндэслэн төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэхэд хүйсийн шилжилтийг бүртгэж болох тухай нэмэлт өөрчлөлт оруулсан. ХДХВ ба ДОХ-ын тухай хуулийг 2012 онд шинэчлэн найруулж, ХДХВ-ын халдвартай хүмүүсийн хувийн асуудал, нууцлалыг хадгалах талаар тусгасан. Мөн Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээс үүдэн ялгаварлан гадуурхахыг хориглосон заалтыг оруулаад байна. Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн төсөл, Хөдөлмөрийн тухай хуулийн төсөлд мөн БЧБХБИ-тэй холбоотой заалт оржээ. Гэвч эрэгтэй, эмэгтэй хүмүүс амьдралаа холбохыг гэр бүл хэмээн тодорхойлсон хэвээр байгаагаас ижил хүйсийн хүмүүс гэр бүл болох буюу уламжлалт бус хүйсийн хүмүүс гэрлэх, түүнээс үүдэлтэй хүүхэд үрчлэх эрх, өмчийн эрх, гэр бүл салахтай холбоотой бусад эрхийг эдлэхэд саад учирч байна. Хүн бүр, түүний дотор ЛГБТ хүмүүсийн тэгш эрхийн зарчмыг хангахын тулд Үндсэн хуулийн ялгаварлан гадуурхахыг хориглосон зүйлд “буюу бусад үндэслэлээр” гэсэн нээлттэй заалт оруулах нь зүйтэй.

- **Бүтэц тогтолцооны орчин:** Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК)-оос ЛГБТ хүмүүсийн эрхийн асуудал, БЧБХБИ-ээр ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглох хэрэгтэй байгаа талаар асуудал дэвшүүлсээр ирсэн. Харин төрийн албан хаагч, тухайлбал, эрүүл мэндийн мэргэжилтэн, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад ЛГБТ хүмүүсийн хүний эрх, БЧБХБИ-тэй холбоотойгоор ялгаварлан гадуурхах асуудлыг ойлгуулах ажил хангалтгүй байна. Судалгаанд оролцсон ЛГБТ хүмүүсийн ихэнх нь хууль сахиулагчдын доромжлолтой тулгарч байсан, зарим тохиолдолд БЧБХБИ-тэй холбоотой сүрдүүлэг, хүчирхийлэлд өртөж байснаа дурдсан байдаг.
- **Соёл, нийгмийн орчин:** Монголын соёл уламжлал ерөнхийдөө өөр хэлбэрийн буюу уламжлалт бус бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн асуудалд тийм ч нээлттэй, таатай ханддаггүй. Ийм сөрөг хандлагад шашны нөлөө нэг их байхгүй, харин уламжлалт хэм хэмжээний үлмаас ЛГБТ хүмүүс өөрсдийгөө түүнд нийцүүлэхийг хичээх эсвэл байр байдлаа нууцлахад хүрдэг. Хэт үндсэрхэг бүлэг, хувь хүмүүсийн зүгээс ЛГБТ хүмүүсийг дарамтлах, гутаан доромжлох, мөн хүнд хэлбэрийн хүчирхийлэл хэрэглэх явдал гардаг байна.

Тус тайланд олон улсын хүний эрхийг хамгаалах механизм Монгол улсад ямар үүрэг гүйцэтгэж байгааг мөн авч үзэв. Монгол Улс хүний эрхийн талаарх олон улсын долоон үндсэн гэрээ конвенцид нэгдсэн орсон нь ЛГБТ хүмүүсийн эрхийг дэмжихэд ихээхэн түлхэц болж буй бөгөөд 2010 оноос хойш хийгдсэн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг<sup>1</sup> (UPR) болон НҮБ-ын бусад механизмийн хүрээнд БЧБХБИ-ийн асуудлыг хүлээн зөвшөөрөх, ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалах тухай зөвлөмж гаргасаар иржээ. Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээг эргэн тайлагнах учраас Засгийн газарт хүний эрхийн талаарх олон улсын хэм хэмжээг дагаж мөрдөх шаардлага тавигддаг. Сүүлийн хэдэн жилийн дотор Монгол Улсын Засгийн газраас олон улсын хүний эрхийн байгууллагуудад тайлан илтгэлээ явуулахаасаа өмнө ажлын хэсэг томилон ажиллуулах, иргэний нийгмийн байгууллагуудтай зөвлөлдөх уулзалт зохион байгуулах зэргээр тайлагнах үйл явцад ахиц дэвшил гарч байна. ЛГБТ хүмүүсийн эрхийн асуудал ч эдгээр хэлэлцүүлгийн хүрээнд байнга яригдсаар иржээ.

Хөдөлмөр эрхлэлт, боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, хэвлэл мэдээллийн хүрээнд ЛГБТ хүмүүст тулгарч буй асуудлын талаар “ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалах нь” бүлэгт авч үзэв. ЛГБТ олон нийтийн байгууллагуудын хөгжил, чадавхийн талаар тайлангийн сүүлчийн бүлэгт дурдав.

<sup>1</sup> Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг бол улс орнууд хүний эрхийн нөхцөл байдал, төрөөс хүний эрхийг хангах талаар авч буй арга хэмжээгээ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд тайлагнахад зориулсан механизм юм. Мөн олон улсын хүний эрхийн хуулийн хүрээнд төрөөс хүлээсэн үүргийг биелэлтийг хүний эрхийн үндэсний байгууллагуудын зүгээс хянах, сануулахад ашигладаг үйл явц юм.

- **Хөдөлмөр эрхлэлт:** Ажлын байранд ялгаварлан гадуурхах асуудал нь хүний эрхийн хамгийн ноцтой, мөн түгээмэл тохиолддог зөрчлийн нэг гэж Монголын ЛГБТ хүмүүс тодорхойлсон байна. Тохиолддог бэрхшээл гэвэл бэлгийн чиг баримжаагаа мэдэгдсэн тохиолдолд ажил олоход хүндрэл учрах, бэлгийн чиг баримжаагаа ил болох вий гэж шаналах, ажлаас халагдах, ялгаварлан гадуурхагдсан тохиолдолд эрхээ сэргээлгэх механизм байхгүй зэрэг болно. Судалгаанд хамрагдсан ЛГБТ хүмүүсийн 80 гаруй хувь нь хамт ажилладаг нөхдөөсөө бэлгийн чиг баримжаагаа нууж явдаг байна. Трансжендэр эмэгтэйчүүдийн хувьд ажил олоход бүр бэрхшээлтэй байдгаас Монголд хууль бус зүйл болох биеэ үнэлэх зам руу орох явдал гардаг байна. Мөн хүчирхийлэл, сүрдүүлгийн хохирогч болох, ядууралд өртөх эрсдэлтэй байдаг.
- **Боловсрол:** Монголд 1998 оноос бэлгийн боловсролын хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн бөгөөд үг хөтөлбөрт БЧБХБИ ба бэлгийн эрүүл мэндийн асуудал орсон байдаг. Гэхдээ багш нар энэ сэдвийг бараг заадаггүй, заасан ч чанар нь хангалтгүй байдаг. Судалгаанд хамрагдсан ЛГБТ сурагчдын ихэнх нь сургууль бол БЧБХБИ-ээ ил мэдэгдэхэд аюулгүй газар биш гэж үзэж байв. Тэдний дөрөвний нэг нь хүмүүсийн ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох явдалтай тулгарч байсан, долоон хувь нь ЛГБТ гэдгээс үүдэн биед нь халдах явдал тохиолдож байсныг дурджээ.
- **Эрүүл мэнд:** Ялгаварлан гадуурхах, таагүй хандах явдал эрүүл мэндийн байгууллагуудад түгээмэл байдаг нь ЛГБТ хүмүүс эрүүл мэндийн тусламж авах боломжийг хязгаарлаж байна. Ерөнхийдөө, ЛГБТ хүмүүст зориулсан эрүүл мэндийн тусгай үйлчилгээ байдаггүй. Цөөн ТББ л ХДХВ-ийн халдвараас сэргийлэх, эмчлэх зэрэг ЛГБТ хүмүүст ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг.
- **Гэр бүл:** ЛГБТ байхыг Монголын гэр бүлд ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөггүй. Нуугдмал байдлаасаа гарсан тохиолдолд гэрийнхэн нь нүд үзүүлэх, биед нь халдах явдал гардаг. Судалгаанд оролцсон ЛГБТ хүмүүсийн 87 хувь нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээ гэр бүл, ойрын хамаатнуудаасаа нуудаг гэжээ. Нийгмийн шахалтын улмаас ЛГБТ хүмүүсийн зарим нь хүсэхгүй байгаа ч аргагүйн эрхэнд эсрэг хүйсийн хүнтэй гэр бүл болох явдал гардаг байна. ЛГБТ асуудлаар ажилладаг ТББ-уудын зүгээс ЛГБТ хүмүүсийн гэр бүлд бага зэрэг мэдээлэл, үйлчилгээ л үзүүлж чадаж байна.
- **Хэвлэл мэдээлэл:** Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл ЛГБТ хүмүүсийг голдуу сөрөг байдлаар дүрслэн харуулдаг. Урьдчилан бүрдүүлсэн хэвшмэл ойлголтоор хүний хувийн асуудалд халдах, үл хүндэтгэх, мэдрэмжгүй хандахын зэрэгцээ ЛГБТ байдлыг нэг бол доог тохуу хийсэн эсвэл өрөвдсөн өнгө аясаар мэдээлдэг. Сүүлийн үед эрхийн талаарх ойлголт сайжрахын хэрээр ЛГБТ хүмүүсийн амьдралтай холбоотой сэдвийг хэвлэн нийтлэхэд зарим нааштай өөрчлөлт гарч байна.

Үндэсний хэлэлцүүлгийн үеэр ЛГБТ олон нийтийн хөгжлийн асуудлаар саналаа солилцож, цөөн тооны ТББ-аас эрүүл мэндийн болон зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж байгаа ч хамт олны дэмжлэг үзүүлэх албан ёсны төв байхгүй байгааг тэмдэглэсэн. 2013 онд зохион байгуулсан “Бахархлын долоо хоног” арга хэмжээ нь анхны бөгөөд түүхэн үйл явдал байсан ажээ. Одоогоор харьцангуй сүүлийн үед байгуулагдсан дөрвөн ЛГБТ олон нийтийн байгууллага Монголд ажиллаж байгаа бөгөөд бүгд Улаанбаатарт байрладаг. Нэг ТББ нь ямар нэг онцгой явдал тохиолдвол ЛГБТ хүмүүс цөөн хоногоор түр байрлах хамгаалах байр ажиллуулдаг. Эдгээр байгууллагын ихэнх нь тогтвортой санхүүжилт байхгүй, олон улсын хандивлагчдын төслийн тогтмол бус санхүүгийн дэмжлэгээр ажиллаж байна. ЛГБТ хүмүүсийн эрхийг дэмжих чиглэлээр ажилладаг нэг ч ТББ Засгийн газраас санхүүгийн дэмжлэг авч байгаагүй ажээ.

## ЗӨВЛӨМЖ

ЛГБТ-тэй холбоотой асуудлаарх Монголын Үндэсний хэлэлцүүлэгт оролцогчдоос гурван гол зөвлөмж, хэд хэдэн тодорхой зөвлөмжийг дэвшүүлэв. Монгол Улсын Засгийн газарт хандсан гурван гол зөвлөмж нь:

1. ЛГБТ хүмүүс айдас хүйдэсгүй амьдарч, эрхээ эдлэх нөхцөлийг хангахын тулд ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль эрх зүйн орчин бүрдүүлэх.
2. ЛГБТ хүмүүсийн эрхийн асуудлыг багтаасан хүний эрхийн талаарх олон нийтийн боловсрол, хэвлэл мэдээлийн стратеги боловсруулан хэрэгжүүлэх.
3. Санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах замаар ЛГБТ олон нийтийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх.

Хэлэлцүүлгээс дараах долоон чиглэлээр авах арга хэмжээг зөвлөмж болгон дэвшүүлсэн. Эдгээр зөвлөмжийг Монгол Улсын Засгийн газар, холбогдох салбарын мэргэжилтнүүдэд хандан гаргав.

### ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ БА БҮТЭЦ ТОГТОЛЦООНЫ ОРЧИН:

- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, бусад холбогдох байгууллагаас ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалах талаар гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээ авах.
- Гэмт хэргийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээс үүдэн ялгаварлан гадуурхахыг хориглох.
- ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалсан зүйл заалт бий болгох үүднээс Монгол Улсын Үндсэн Хууль (1992)-ийн 14 дүгээр зүйлд “бусад үндэслэлээр” гэсэн нэмэлт тодотгол оруулах асуудлыг авч үзэх.
- ЛГБТ олон нийт гэх мэт цөөнхийн асуудлаар одоо үйлчилж буй хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангах.
- Холбогдох хууль тогтоомж, бодлогын ялгаварлан гадуурхахыг хориглосон зүйл, заалтын хэрэгжилтийг хянахад зориулсан удирдамж, үзүүлэлт боловсруулан ашиглах.
- ЛГБТ олон нийтийн онцлог хэрэгцээнд тохирсон хууль зүйн туслалцаа үзүүлэх аргачлал боловсруулах, үүнд Эрх зүйн туслалцаа үзүүлэх газарт хариуцсан ажилтантай болох.
- Ажлын байр, боловсролын салбар, хэвлэл мэдээлэл зэрэг нийгмийн амьдралын бүхий л хүрээнд БЧБХБИ-ээр ялгаварлан гадуурхахын эсрэг бодлого баталж, хэрэгжүүлэх.
- Ижил хүйсийн хүчинг хуулийн зохих заалтын дагуу мөрдөн шалгаж, ялладаг байх.
- ЛГБТ хүмүүсийн талаар олон нийтийн дунд эерэг хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн сурталчилгаа явуулах.
- ЛГБТ хүмүүсийн оролцоог хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх замаар иргэний нийгмийн байгууллагуудын хүний эрхийн үйл ажиллагааг өргөжүүлэх.
- ЛГБТ хүмүүст ээлтэй байгууллага, бизнес, орон зай, хамт олонг дэмжин өргөжүүлэх.

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- ЛГБТ хүмүүсийг ажилд авах, ажлын байрыг нь хадгалахад ялгавартай хандаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад БЧБХБИ-тэй холбоотойгоор ажлын байран дээр ялгаварлан гадуурхахыг хориглосон заалт оруулах.
- Одоо үйлчилж буй хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг ЛГБТ асуудалтай холбон эргэн харах, зөрчигдсөн тохиолдолд Хүний эрхийн үндэсний комисс зэрэг төрийн холбогдох байгууллагаар дамжуулан эрхийг сэргээх арга хэмжээг авч ажиллах.
- Хүний нөөцийн ажилтан бэлтгэж буй их дээд сургуулийн хөтөлбөрт хүний эрхийн боловсрол олгох сэдвийг тусгах.
- ХДХВ ба ДОХ-ын тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах.

- ЛГБТ хүмүүсийг ажлын байранд хамгаалах талаар мөрдөгдөж буй хуулиудыг ажил олгогч нарт ойлгуулан таниулах.

## БОЛОВСРОЛ

- БЧБХБИ-ийн асуудлаар ойлголт мэдлэг олгох үүднээс албан болон албан бус боловсролын хүрээнд бэлгийн боловсролын хөтөлбөрийг буцаан оруулах.
- Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах хандлагыг төлөвшүүлэхийн тулд боловсролын байгууллагууд бодлого гарган хэрэгжүүлэх.
- Сургуулиудад зориулсан хууль эрх зүйн болон ёс зүйн сургалтын багц боловсруулан ашиглах.
- Сургуулиудыг ЛГБТ хүмүүсийн эрхийн асуудлаар бэлтгэгдсэн ажилтантай болгож, ЛГБТ оюутнуудад эрх зүйн болон бусад зөвлөгөө авах хэрэгцээ гарсан үед холбогдох газар руу илгээх үйлчилгээ үзүүлэх.
- Монголын бүх иргэнд албан болон албан бус боловсролын хүрээнд хүний эрхийн боловсрол олгох талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ингэснээр ялгаатай байдал, гэр бүлийн өөр хэв шинж, хэлбэрт хүлээцтэй, хүндэтгэлтэй хандах явдлыг хөхиүлэн дэмжих.

## ЭРҮҮЛ МЭНД

- Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн төгсөлтийн өмнөх, дараах болон ажлын байран дахь сургалтын хөтөлбөрт БЧБХБИ-тэй холбоотой сэдэв оруулах.
- ЛГБТ хүмүүсийн эрх, эрүүл мэндийн онцлог хэрэгцээний талаар эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын материал боловсруулах.
- ЛГБТ хүмүүст шаардлагатай онцлог тусламж үйлчилгээний талаар эрүүл мэндийн холбогдох мэргэжилтнүүдэд сургалт явуулах. Тухайлбал, лесбиян, бисексуал эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн эх барих эмэгтэйчүүдийн тусламж үзүүлэх, сэтгэл гутралд автдаг ЛГБТ хүмүүст зориулсан сэтгэл зүйн цогц зөвлөгөө өгөх, трансжендэр хүмүүст хүйсийн шилжилтийн мэс засал хийлгэх боломж бүрдүүлэх гэх мэт.
- ЛГБТ хүмүүст шаардлагатай эрүүл мэндийн онцлог тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлыг (тухайлбал даавар нөхөх, хүйсийн шилжилтийн мэс засал, сэтгэл зүйн зөвлөгөө гэх мэт) холбогдох хууль тогтоомжид нэмж тусгах, үндэсний эрүүл мэндийн даатгалд хамруулах.
- Трансжендэр хүмүүст шаардлагатай эрүүл мэндийн онцлог тусламж үйлчилгээг Эрүүл мэндийн яамнаас баталсан гадаадад эмчилгээ хийлгэхэд санхүүгийн дэмжлэг олгох жагсаалтанд уг үйлчилгээг өөрийн оронд авах боломж бүрдтэл түр хугацаагаар нэмж оруулах.
- ЛГБТ хүмүүст ээлтэй, тэдэнд эрүүл мэндийн цогц үйлчилгээ үзүүлж буй хувийн болон төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэх.
- ХДХВ-ын халдвараас сэргийлэх зорилтот арга хэмжээг өргөжүүлэхийн тулд бэлгийн цөөнх эрэгтэйчүүдтэй ажилладаг ТББ-уудын байгууллагын чадавхийг бэхжүүлэх, мөн үйл ажиллагааны үндсэн, тогтвортой санхүүжилтийн механизмыг бүрдүүлэх.

## ГЭР БҮЛ

- БЧБХБИ ба ЛГБТ хүмүүсийн нэр төр, эрхийг хүндэтгэх талаар олон нийтэд зориулсан мэдээллийн цогц аяныг зохион байгуулах.
- ЛГБТ хүмүүсийн гэр бүлд зөвлөгөө өгөх асуудлаар сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудыг сургах.
- ЛГБТ хүмүүсийн амьдралыг харуулсан кино, баримтат кино, цуврал кино, ярилцлага зэргийг Монголын үндэсний олон нийтийн телевиз, радиогоор нэвтрүүлэх зэрэг арга замаар ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах талаар ЛГБТ хүмүүсийн гэр бүл, эцэг эхийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх.

- ЛГБТ эцэг эхийн гар дээр өсч буй хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах хяналтын механизм бүрдүүлж хэрэгжүүлэх.

#### **ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ**

- ЛГБТ-тэй холбоотой асуудлаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ашиглах туйлшраагүй, мэдрэмжтэй, зөв нэр томъёоны тайлбарыг боловсруулан түгээх.
- Хэвлэл мэдээллийн байгууллага ЛГБТ-тэй холбоотой асуудлыг бодитой хэвлэн нийтлэх бодлого гарган мөрдөхийг уриалан дэмжих.
- Харилцааны холбооны зохицуулах зөвлөлөөс цахим мэдээллийн хэрэгслүүдэд ашиглахыг хориглосон үгсийн жагсаалтаас ЛГБТ-тэй холбоотой ердийн утга агуулга бүхий нэр томъёог хасах.
- БЧБХБИ-ийн асуудлыг үнэн зөв, мэдрэмжтэй таниулах, тогтмол сургалт сурталчилгаа явуулах замаар хэвлэл мэдээллийн хэрэгслийн оролцоог дэмжих, өргөжүүлэх.
- ЛГБТ хүмүүсийн эрхийг дэмжих, ялгаварлан гадуурхахгүй байх, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах явдлыг нийтэд ойлгуулахад интернет, нийгмийн мэдээллийн сүлжээний давуу талыг ашиглах.

#### **ЛГБТ ОЛОН НИЙТИЙН ХӨГЖИЛ БА ЛГБТ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАДАВХИ**

- ЛГБТ олон нийтийн хөгжил, эрх мэдэлжүүлэх асуудлаар урт хугацааны стратеги боловсруулахыг дэмжих.
- Цогц үйлчилгээ үзүүлэх тогтвортой ажиллагаатай олон нийтийн төвийг байгуулах.
- Одоо ажиллаж буй ЛГБТ байгууллагуудын мэргэжлийн болон санхүүгийн чадавхийг бэхжүүлэх.
- ЛГБТ хүмүүсийн амьдралд нөлөөлөх бодлого, хөтөлбөр, санаачлагыг боловсруулахад тэдний оролцоог хангах.
- Үндэсний болон бүс, олон улсын түвшинд хүний эрхийн асуудлаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулах ажлын хэсэг байгуулах.



## УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр, ялангуяа олон улсын хүний эрхийн механизмын хүрээнд, ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалах асуудалд ихээхэн анхаарал хандуулж байна. Гэвч дэлхийн улс орнуудад лесбиян, гей, бисексуал, трансжендэр хүмүүс бэрхшээлтэй тулгарсаар л байна. Тухайлбал, ЛГБТ байхыг хууль бус гэж үзэх, хүчирхийлэлд өртөх, хөдөлмөр эрхэлж чадахгүй байхын зэрэгцээ (Sears & Mallory, 2011), эрүүл мэндийн тусламж хүртэх (Winter, 2012), орон байртай болж (Grant, Mottet & Tanis, 2011), боловсрол (Burns, 2011) эзэмшихэд гадуурхагдах бэрхшээлтэй тулгарч байна. Ихэвчлэн Африк, мөн Өмнөд Азид лесбиян эмэгтэйчүүдийг “хүчингээр залруулах” явдал гарч (Brown, 2012), тэгш байдал, ялгаварлан гадуурхалт, хавчлагын бүх хэлбэрээс ангид байхыг уриалсаар байхад ЛГБТ хүмүүсийн амь насыг хөнөөх явдал ч улс орнуудад гарсаар байгаа зэрэг жишээг дурдаж болно. 2008-2012 онд 1,083 трансжендэр хүн бусдын гарт амь насаа алдсан тухай Трансжендэр Европ байгууллага 2012 онд мэдээлжээ.

2011 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл 17/19 тоот тогтоолыг баталсан нь хүний эрх, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн асуудлаар НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарын газраас (НҮБ-ын ХЭДКГ, 2011) НҮБ-ын анхны тайлан илтгэл гарах замыг нээж өгсөн байна. Тус илтгэлд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээс үүдэн хүмүүс ялгаварлан гадуурхагдаж байгаа, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн тусламж, эмчилгээ үйлчилгээ, нийгмийн дэмжлэг ба боловсрол дахь тэгш бус байдал, түүнчлэн гэмт хэрэгт татагдах, бие махбодийн хүчирхийлэл, хүн амины хэргийн хохирогч болж байгаа талаарх баримт нотолгоог танилцуулсан юм. ЛГБТ хүмүүст олонтаа тулгарч буй ялгаварлан гадуурхалтыг эцэс болгон НҮБ-ын түүхэнд нэгэн шинэ мөр гаргахад туслахыг Дээд комиссар Нави Пиллай НҮБ-ын гишүүн орнуудад уриалсан билээ.

Энэхүү уриалга АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтоны 2011 оны 12 дугаар сард Олон улсын Хүний эрхийн өдрийг тохиолдуулан ЛГБТ хүмүүсийн эрхийн талаар хэлсэн үгэнд тусгалаа олсон. Тэрээр ЛГБТ хүмүүс баривчлагдаж, зодуулж, сүрдүүлэгт өртөж, бүр амь насаа ч алдаж буй “үл анзаарагдах цөөнх” хэмээн тэмдэглэсэн юм. Тэдний нэлээд нь “бусад иргэдийн жигшил зэвүүцэл, хүчирхийллийг амсаж байхад тэднийг хамгаалах үүрэг бүхий эрх мэдэлтнүүд тэднээс нүүр буруулах, тэр ч



бүү хэл хүчирхийлэлд нэгдэх ч явдал байна”. Жишээ нь, 2009 онд Угандад ижил хүйсийн хүмүүс бэлгийн харьцаанд орвол насаар нь хорих тухай хуулийн төсөл боловсруулсан. Улмаар Угандагийн Ижил хүйсийн хүмүүсийн бэлгийн харьцааны эсрэг хууль (2014) парламентаар 2013 оны 12 дугаар сард батлагдаж, 2014 оны 2 дугаар сард Ерөнхийлөгч нь гарын үсэг зуржээ. Харин 2014 оны 8 дугаар сард Үндсэн хуулийн шүүхээс түүнийг хүчингүй болгосон байна. Энэхүү харгис хуулинд зааснаар ижил хүйсийн хүмүүс бэлгийн харьцаанд орж, гэр бүр болсон бол бүх насаараа хоригдох ял сонсох байснаас гадна ижил хүйсийн хүмүүсийн бэлгийн харьцааг “дэмжсэн”, ЛГБТ хүмүүсийн эрхийг дэмжсэн бол мөн хатуу чанга хорих ял оноохоор заасан байв.

2011 оны 12 дугаар 6-нд АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама ЛГБТ хүмүүсийн Хүний эрхийн байдлыг сайжруулах тухай Олон улсын санаачлагын талаарх Санамж бичгийг баталсан. Энэхүү санамж бичигт АНУ-ын дипломат үйл ажиллагаа, гадаадын тусламжийн хүрээнд ЛГБТ хүмүүсийн хүний эрхийг хамгаалах, дэмжих талаар хилийн чанадад үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллагад чиглэл өгсөн байна. 2012 оны 3 дугаар сарын 7-нд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүүн БЧБХБИ-тэй холбоотой хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтын талаар Хүний эрхийн зөвлөлийн хуралдаанд үг хэлсэн. Тэрээр хүмүүсийг зүгээр л ЛГБТ гэдгээр нь хүчирхийлэх, ялгаварлан гадуурхах явдал гарч байгааг тэмдэглээд “энэ бол үүнд өртөж буй хүмүүст гашуун эмгэнэл, бидний хамтын ухамсард үлдэж буй хар толбо юм. Мөн олон улсын хуулийг зөрчиж байгаа хэрэг” гээд “арга хэмжээ авах цаг болсон” гэдгийг чухалчлан мэдэгдсэн билээ.

ЛГБТ эрхийн асуудлаар Монгол улсад болон дэлхий нийтэд сүүлийн үед ахиц дэвшил гарч байгаа нь сайшаалтай. Монгол Улс 1998 онд ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт БЧБХБИ-ийн асуудлыг оруулсан Азийн анхны орон болсон. Гэрлэлтийн тэгш байдлыг дөрвөн тивийн 14 оронд хуульчлаад байна (Itaborahy & Zhu, 2013). Энэтхэг, Балба, Пакистан улсын Дээд шүүхээс трансжендэр хүмүүсийг хүлээн зөвшөөрч, тэдэнд хуулийн хамгаалалт олгосон бол Вьетнам, Тайландад гей хос хүүхэд үрчлэхийг янз бүрийн цаг үед зөвшөөрсөөр ирсэн байна. Хятадад ижил хүйсийн хүмүүсийн бэлгийн харьцааг сэтгэцийн эмгэгийн ангиллаас хассан. БЧБХБИ-ээр ялгаварлан гадуурхахын эсрэг хамгааллын асуудал Өмнөд Африк, Өмнөд Америк, Европын хэд хэдэн орны үндсэн хуульд тусгагджээ. ЛГБТ иргэдийг зэвсэгт хүчинд алба хаахыг хориглосон бодлогоо АНУ, бусад зарим орон цуцлаад байна.

Дэлхий нийтэд ЛГБТ эрхийн талаар ихээхэн ахиц гарч байгаа ч 83 улс орон, газар нутагт ЛГБТ зан үйлийг гэмт хэрэг хэмээн үздэг, долоон орон ижил хүйсийн хүмүүсийн бэлгийн харьцаанд цаазаар авах ял оноодог хэвээр байгаа бөгөөд гей хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг бүрэн эсвэл ямар нэг хэмжээгэр хориглоод буй орны тоо 50 болсныг цаашид нэмэгдүүлэх хэрэгтэй байна (АНУ-ын ОУХА).



## МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ЛГБТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монголын Үндэсний ЛГБТ хэлэлцүүлэг 2014 оны 3 сарын 20-21-нд Улаанбаатар хотод НҮБ-ын байранд болсон бөгөөд “Азид ЛГБТ байх нь” санаачлагын Монгол улсад явагдсан нэг гол арга хэмжээ байв. Үндэсний хэлэлцүүлгийг НҮБ-аас АНУ-ын ОУХА-тай хамтран зохион байгуулж, ЛГБТ олон нийт, идэвхтэн, хүний эрхийн шинжээч, иргэний нийгэм, төрийн байгууллагын ажилтнууд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, АНУ-ын ОУХА болон хөгжлийн бусад түншийн төлөөлөл оролцсон.

Хэлэлцүүлгийн эхний өдөр ЛГБТ олон нийт тэдэнд тулгарч буй бэрхшээл, боломжийн талаар хэлэлцэж, ЛГБТ эрхийг хэрхэн сайжруулах талаар оролцогч талуудад хандан зөвлөмж гаргасан. Оролцогчдын дийлэнх нь гей (30 хүн), хоёр нь бисексуал эрэгтэй байснаас гадна



ЛГБТ олон нийт дотор оролцоо багатай байдаг лесбиан эмэгтэйчүүдийн төлөөлөл гурав, трансжендэр эмэгтэй гурав, трансжендэр эрэгтэй нэг, дэмжин оролцогч бусад хүмүүс 18 байв. Нийт 57 оролцогчоос зургаа нь Дархан, Эрдэнэт, Дорноговиос ирсэн байв.

Хоёр дахь өдрийн хэлэлцүүлэг дээр эхний өдөр хэлэлцсэн ЛГБТ асуудлыг танилцуулах зорилготой байсан. Уг арга хэмжээг Монгол Улсын засгийн газрын төлөөлөл, ТББ, хэвлэл мэдээллийн төлөөлөл, хөгжлийн бусад түнш оролцсон нээлттэй хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулсан юм. Нийт 81 оролцогчийн 25 нь төрийн байгууллагаас, 17 нь НҮБ, АНУ-ын ОУХА-ын Азийн бүсийн болон Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, хөгжлийн түнш, олон улсын бусад байгууллагын төлөөлөгч байв. Иргэний нийгмийг төлөөлөн ЛГБТ төв, Залуус ба эрүүл мэнд, Хамтдаа төв, Өөдрөг амьдрал-Дэмжих төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Монголын залуучуудын холбоо зэрэг байгууллагаас 13 хүн оролцов. Мөн их дээд сургууль (МУИС, Хэвлэлийн хүрээлэнгийн Сэтгүүл зүйн сургууль), судлаачид, хэвлэл мэдээллийн төлөөлөл болон есөн сэтгүүлч оролцсон.

Уг арга хэмжээг оролцооны арга барилаар явуулсан нь ЛГБТ байгууллага, хувь хүмүүс санаа зовоосон асуудлаа гаргаж ирэх, туршлагаа хуваалцах, Монголын ЛГБТ олон нийтийн тулгамдсан асуудлыг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн шийдвэрлэх бодитой, бүтээлч санал дэвшүүлэх боломж олгосон юм. Эхний өдөр олон нийтийн төлөөлөл боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл, хэвлэл мэдээлэл, олон нийт ба соёл уламжлалтай гэсэн сэдвээр ярилцсан. Сэдэв тус бүрээр бүлгээр ажиллан, хамгийн ноцтой асуудлыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмж боловсруулав. Хэлэлцүүлгийн хоёр дахь өдөр бүлэг бүрийн идэвхжүүлэгч хэлэлцүүлгийн тоймыг нэгдсэн хуралдаанд танилцуулсан.

Оролцогч, ажиглагчдын зүгээс уг хэлэлцүүлэг нь Монголд ЛГБТ-тэй холбоотой асуудлыг авч үзэх үйл явцад нэг чухал хуудас боллоо гэдэгтэй санал нэгтэй байв. Хэлэлцүүлгийн үеэр

мэдээлэл, санал бодлоо урьд байгаагүй идэвхтэй солилцсон нь тэнд цугласан олон хүнд шинэ зүйл байсан юм. Хууль зүйн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөрийн яамны төлөөлөл оролцож, ЛГБТ олон нийтэд тулгарч буй бэрхшээлтэй холбоотой асуудлуудад хариулт өгсөн. Мөн Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц. Оюунгэрэл хэлэлцүүлгийг нээж, орлоцогчдод урам өгсөн үг хэлсэн билээ. Тэрээр ЛГБТ хүмүүстэй холбоотой асуудлыг амьдралын бүхий л хүрээнд авч үзэх ёстой, ялангуяа тэдний гэр бүл, найз нөхөд хүлээн зөвшөөрч, ойлгодог байх тухай асуудал бол Монголын соёлын салбарын хүрээнд шийдвэрлэх ёстой нэг асуудал болохыг онцлон тэмдэглэсэн юм. Ерөнхийдөө, Үндэсний Хэлэлцүүлэг нь ЛГБТ эрх, хууль эрх зүйн болон нийгмийн орчны зүгээс Монголын ЛГБТ хүмүүст тулгарч буй асуудлын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, ЛГБТ хүний эрхийг баталгаажуулахын тул цаашид хийх ажлын талаар чухал саналуудыг дэвшүүлээ гэж оролцогчид дүгнэж байв.




## АЗИД ЛГБТ БАЙХ НЬ

“Азид ЛГБТ байх нь: ЛГБТ хүмүүс, иргэний нийгмийн талаарх хууль эрх зүй, нийгмийн орчны оролцоонд суурилсан үнэлгээ, шинжилгээ”-гээр НҮБХХ, АНУ-ын ОУХА хамтран Азийн зарим оронд ЛГБТ олон нийт, тэдний хүний эрхийн нөхцөл байдлыг авч үзэн, улс орон, хамт олны түвшинд ЛГБТ эрхийн нөхцөл байдлыг шинжлэн, зураглал гаргах, ойлголтыг гүнзгийүүлэх зорилго тавьсан. Уг санаачлага нь дэлхий дахинд ЛГБТ хүмүүс хүний эрхийн бэрхшээлтэй тулгарсаар байгаа ч НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, НҮБХХ-ийн захирагч, НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссар, АНУ-ын Ерөнхийлөгч, Төрийн нарийн бичгийн дарга уг асуудалд анхаарал хандуулах зэргээр олон улсын хүчин чармайлт нэмэгдэж буй цаг үед явагдаж байна.

Чухал шинэ мэдлэг бий болгож, холбоо харилцааг бэхжүүлснээр “Азид ЛГБТ байх нь” санаачлага нь Зүүн, Өмнөд ба Зүүн өмнөд Ази дахь ЛГБТ байгууллагуудын сүлжээг бэхжүүлэх, оролцооны арга барил түүний дотор видео, интернет, нийгмийн сүлжээ зэрэг шинэлэг арга хэлбэрийг ашиглах замаар хөгжлийн явцад бодлого хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд тус дэм болохыг зорьсон. Мөн бие биеэсээ харилцан суралцах, хууль эрх зүйн болон хүний эрхийн асуудлаар суурь мэдээлэл буй болгон, ЛГБТ идэвхтнүүдийн мэдэл, чадавхийг дэмжихийг зорьсон. Энэ нь мультимедиа, нийгмийн сүлжээнд зориулсан арга хэрэгсэл, материал бүтээх, ЛГБТ иргэний нийгмийн үйл ажиллагааг дэмжихэд залуу манлайлагчдыг оролцуулах, НҮБ, АНУ-ын Засгийн газраас Ази дахь ЛГБТ иргэний нийгмийн байгууллагуудтай ажиллах чадавхийг нь сайжруулахад хувь нэмрээ оруулахыг зорьсон.

“Азид ЛГБТ байх нь” санаачлагын нэг чухал зорилго нь хөгжлийн түнш, засгийн газар, ЛГБТ иргэний нийгмийн байгууллага, шашины байгууллага зэрэг бүс нутгийн хэмжээнд ЛГБТ асуудлаар ажиллаж буй, шинээр гарч ирж буй бүхий л байгууллага, хувь хүмүүс хамтдаа асуудлыг хэлэлцсэнээр талууд ЛГБТ-ийн оролцоог хангасан хөгжлийн хандлага, хөтөлбөр хэрэгжүүлэхэд нь нэмэр болохыг чухалчилсан явдал юм. Улс бүрт зохион байгуулсан “Үндэсний олон нийтийн хэлэлцүүлэг” нь уг санаачлагын эхний гол арга хэмжээ юм.



# ЛГБТ МОНГОЛЧУУДЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТОЙМ



## МОНГОЛ ДАХЬ ЛГБТ АСУУДЛЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ БА ӨРНӨЛ

Монголын ЛГБТ хүмүүсийн 20 дугаар зуунаас өмнөх үеийн нөхцөл байдал нь судлагдаагүй байгаа асуудал бөгөөд цаашид түүхийн талаас нь судалснаар тус улс дахь ЛГБТ эрхийн өнөөгийн нөхцөл байдал, өмнөх үеийг сайн ойлгоход тус болох юм. Энэ асуудлаар бичигдсэн, ижил хүйсийн хүмүүс, трансжендэр хүмүүсийн талаар зориуд авч үзсэн цөөн материал нь Монголын зонхилох шашин, итгэл үнэмшил болох буддизм, бөөгийн ерөнхий үзэл санаанд тулгуурласан байдаг. Дээрх шашин, итгэл үнэмшил нь олон зууны турш монголчуудын оюун санаа, нийгмийн амьдралд нөлөөлсөөр ирсэн бөгөөд аль аль нь ижил хүйсийн хүмүүсийн харилцааг битүү хүлээн зөвшөөрдөг гэж үздэг байна (Harvey & Wallis, 2007; Nyamdorj & Garner, 2008). Өнөөг хүртэл Монголд олонд хүлээн зөвшөөрөгдсөн шашны зүтгэлтнүүдээс ижил хүйсийн хүмүүсийн харилцааны эсрэг нийтэд хандсан мэдэгдэл хийж, үйл ажиллагаа явуулж байгаагүй ажээ.

Монгол Улс 1924 онд социалист үзэл санааг нэвтрүүлж, энэ нь далан жил үргэлжилсэн. Энэ хугацаанд бэлгийн болон жендэрийн цөөнхийн талаар ерөнхийдөө нэг их яриад байдаггүй, өөрөөр хэлбэл, хаалттай сэдэв байсаар ирсэн. ЛГБТ-ийн талаарх олон нийтийн ойлголт ч хомс байв. Социализмын үеийн ЛГБТ хүмүүсийн нөхцөл байдлыг харуулсан хүн судлалын болон бусад судалгаа бараг байхгүй. Архивын материалд үндэслэн түүхийн судалгаа хийвэл тухайн цаг үеийн ЛГБТ хүмүүсийн амьдралыг бодитой ойлгох боломжтой болох юм.

Монгол улс ардчилсан нийгмийн харилцаанд шилжин, 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталснаар хүний эрх, эрх чөлөө түүний дотор иргэний, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах суурь тавигдсан билээ. Мөн “гурав дахь үеийн” хүний эрхэд тооцогддог эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ч баталгаажуулсан. Гэвч 1999 онд “Тавилан” хэмээх гей эрчүүдийн хүний эрхийн байгууллага гарч ирснээр л ЛГБТ эрхийн асуудал нийтийн хүрээнд

яригддаг сэдэв болжээ. Тус ТББ-ын гол зорилго нь ХДХВ ба бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-аас сэргийлэхэд түлхүү анхаарч, бэлгийн чиг баримжаа, аюулгүй бэлгийн харьцааны талаар хэрэгцээтэй мэдээллийг түгээх явдал байжээ.

2000-аад оны эхэн үед ЛГБТ эрхийн асуудлыг бэлгийн эрүүл мэндийг дэмжих асуудалтай нягт холбон авч үзэж байлаа. 2003-2009 оны хооронд ийм зорилго бүхий Залуус эрүүл мэнд төв, Хамтдаа төв, Хүний эрх-залуучууд-эрүүл мэндийг дэмжих төв (“Дэмжих төв” гэгддэг) ТББ байгуулагдсан. Энэ гурван байгууллага бүгд эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд (ЭБЭ)-д хандсан БЗДХ, ХДХВ-ын халдвар, нууцлалыг хадгалсан шинжилгээний талаарх мэдээлэл түгээх, вирусын эсрэг эмчилгээнд зуучлах ажил хийж ирсэн. Олон талт хандивлагчид ХДХВ-ийн урьдчилан сэргийлэлт, эмчилгээнд дэмжлэг үзүүлж эхэлсэн 2001 оноос ЭБЭ нь ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх ажлын зорилтот хүн амын бүлгийн нэг болсон байна.

1998 онд Засгийн газар бэлгийн чиг баримжааны талаарх сэдэв бүхий бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн хичээлийн үндэсний хөтөлбөрийг баталсан. Бэлгийн чиг баримжаа, жендэрийн сэдвийг 6-9 дүгээр ангид зааж, бэлгийн чиг баримжааны талаарх ташаа ойлголт, бодит байдлыг ялган зөв таних талаар Эрүүл мэндийн боловсролын стандартад тусгасан байна. “Бэлгийн боловсрол 1”, “Бэлгийн боловсрол 2” сурах бичигт ЛГБТ хүмүүсийн амьдралын бодит түүхээс оруулсан байдаг (Эрүүл мэндийн яам, 2008). Гэвч Монголын багш нар эдгээр сэдвийг сургуульд ямар аргаар хэрхэн зааж байгаад хяналт бараг тавилгүй явж ирсэн бөгөөд цаашид Боловсрол, шинжлэх ухааны яамнаас анхаарвал зохих асуудал юм.

2007 онд ЛГБТ төв байгуулагдаж, хүний эрхэд суурилсан арга барилд анхаарал хандуулах болсноор ЛГБТ эрхийн асуудлыг дэмжих ажил хүрээгээ тэлсэн. Цөөн жилийн дотор голдуу Улаанбаатарт төвлөрч буй Монголын ЛГБТ олон нийт ЛГБТ эрхийг хүний эрхийн нэг чухал асуудал болгон удаа дараа анхаарал хандуулж ирэв. Тухайлбал, 2010 онд явагдсан НҮБ-ын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн (UPR) хүрээнд Хүний эрхийн хороонд цөөнхийн эрхийн талаарх тайлан хүргүүлэхэд ЛГБТ төв оролцсон байна. Үүний үр дүнд Хүний эрхийн тогтмол түгээмэл хяналтын зөвлөмжид Монгол дахь ЛГБТ хүний эрхийн өнөөгийн байдлыг сайжруулах зөвлөмж оржээ.

2012 онд Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК) жил бүр гаргадаг Хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэлд анх удаа Монгол дахь ЛГБТ эрхийн тухай бүлэг оруулсан. Тус илтгэлд ЛГБТ хүмүүсийн хүний эрхийг, тухайлбал, ялгаварлан гадуухагдахаас ангид байх эрх, гэр бүл зохиох эрх, ЛГБТ хүмүүсийн хүүхдийн эрх, хөдөлмөрлөх, эрүүл мэндийн тусламж, боловсрол ба хувь хүний аюулгүй байдлыг хангах эрх ноцтой зөрчигдөж байгаад анхаарал хандуулсан байна. Хууль сахиулах байгууллагад хэргийг мэдэгдэхэд мөрөөр нь арга хэмжээ авдаггүйгээс эхлээд олон нийтийн газар ЛГБТ хүмүүс хүчирхийлэлд өртсөн тохиолдлууд зэрэг аюулгүй байдалтай холбоотой асуудлыг үг илтгэлд дурджээ. Илтгэлийг хэлэлцээд УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос 13 тоот тогтоол гарган, түүнд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсын Засгийн газарт өгсөн гей, лесбиян, бисексуал, трансжендэр (ЛГБТ) хүмүүсийн хүний эрхэд хамаарах зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгажээ.

Өнгөрсөн хугацаанд ЛГБТ хүмүүсийн эрхийг дэмжин ажилладаг иргэний нийгмийн байгууллагын тоо өсөн нэмэгдсэн. Тухайлбал, Нээлттэй нийгэм форум, Хүний эрх ба хөгжил төв, Монфемнет–Эмэгтэйчүүдийн ТББ-уудын үндэсний сүлжээ, Хүчирхийллийн эсрэг



үндэсний төв, Глоб Интернэйшнл, Оюуны дархлаа, ДОХ-ын үндэсний сан, Хүний хөгжил нөхөн үржихүйн эрүүл мэнд/эрх ТББ-ын сүлжээ, Монголын эмэгтэйчүүдийн сан зэрэг болно. Иргэний нийгэм, хүний эрхийн байгууллагууд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд тэгш хамгааллын төлөө ажиллахын сацуу тэдний эцсийн зорилго нь ялгаварлан гадуурхалтаас ангид нийгмийг бүтээн байгуулах явдал юм.



## МОНГОЛ УЛС БА ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН МЕХАНИЗМ

Монгол Улсын Үндсэн Хуулинд (1992) “Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлцлүүд нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон цагаас үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр болно” гэж заажээ (Зүйл 3). Хүний эрхийн түгээмэл тунхаглалд (1948) хүн бүр “арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан” адил тэгш эрх ба эрх чөлөөтэй болохыг тунхагласан билээ (Зүйл 2). Монгол Улс нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт (ЭЗНСЭОУП) зэрэг олон улсын хүний эрхийн 30 орчим гэрээ конвенцэд нэгдсэн. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбогдуулан олон улсын хүний эрхийн хуулийг хэрэглэх тухай Жогжакартын зарчимд олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийг соёрхон баталсан улс орнууд хүний эрхийг бүрэн дүүрэн хангахдаа ЛГБТ хүмүүсийг орхигдуулж үл болно гэж заасан. Хүний эрхийг хангах тухай олон улсын эдгээр механизм нь Монгол Улсад ЛГБТ эрхийн асуудалд анхаарал хандуулахад ихээхэн түлхэц болж буй юм. Жишээлбэл, Боловсролын эрхийн талаарх Тусгай илтгэгч (2009) “зөвхөн сургуулийн хүрээнд төдийгүй Монгол улсын нийт хүн амын дунд хүний эрхийг дээдэлсэн соёлыг бүрдүүлэх нь чухал болохыг” онцлон тэмдэглээд Монгол хэл дээр хэвлэгдсэн хүний эрхийн ном, гарын авлага хомс байгааг сануулсан байна.

Монгол Улс 2010 онд Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэгт тайлангаа хүргүүлсэн. Уг тайланг авч хэлэлцээд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс ЛГБТ эрхтэй холбогдох хэд хэдэн зөвлөмж өгсөн. Үүнд:

- Ялгаварлан гадуурхахын эсрэг өргөн утгаар нь авч үзсэн хуулийг батлан, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээс үүдэн ялгаварлах явдлыг хуулиар хориглох;
- Бэлгийн чиг баримжаатай холбоотой ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийн бүх хэлбэрийг нийтэд хандан буруушаах, бэлгийн чиг баримжаатай холбоотойгоор хувь хүмүүсийн эсрэг заналхийлсэн, халдсан бүхий л хэргийг мөрдөн шалгах, яллах;
- ЛГБТ хүмүүсийн эрхийг баттай хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж боловсруулах, мэдээлэл, хүний эрхийн боловсролоор дамжуулан улс орондоо ялгаварлан гадуурхах үзэл санааг өөгшүүлэхгүй байх;
- Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотойгоор хувь хүмүүсийг заналхийлэх, халдсан тухай аливаа мэдэгдлийг нягт нямбай, шударгаар мөрдөн шалгаж, хуулийн хариуцлага ноогдуулах (2011 оны 1 дүгээр сар, А/НRC/16/5).

2011 оны 4 дүгээр сард Монгол Улсын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП)-ын хэрэгжилтийн тайлантай танилцаад, НҮБ-ын Хүний эрхийн хорооноос ялгаварлан гадуурхалтын талаарх Монголын “хууль тогтоомжид томоохон цоорхой” байгааг,



Үндсэн хуулийн 14 дүгээр зүйл дэх ялгаварлан гадуурхалтыг хориглох тухай заалт асуудлыг цогц илэрхийлээгүй”-д санаа зовниж байгаагаар илэрхийлээд “түгээмэл тохиолдож байгаа ЛГБТ хүмүүст ялгавартай хандах, нийгмийн зүгээс адлах, гутаан доромжлох явдлыг таслан зогсоох талаар шийдвэртэй арга хэмжээ авах”, түүнчлэн “ЛГБТ хүмүүс хууль ёсны эрхээ хамгаалуулах, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотойгоор хувь хүмүүсийн эсрэг аливаа аюул занал үйлдсэн нь мэдэгдэх аваас нягт нямбай мөрдөн шалгаж байх” шаардлагыг Монгол Улсад тавьсан байна.

Туйлын ядуурал ба хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгч 2012 онд Монгол улсад ирж ажиллаад, 2013 оны 5 дугаар сард тайлангаа ирүүлсэн. Тусгай Илтгэгч ЛГБТ олон нийтийн дийлэнх нь ялгаварлан гадуурхалттай холбоотойгоор ажил олох, боловсрол эзэмшихэд хүндрэлтэй байдгаас ядууралд өртөж байгааг тэмдэглээд, 2010 оны Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхийг Засгийн газарт мэдэгджээ.

2011 оны 1 дүгээр сард Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос гаргасан “Ажиглалтын дүгнэлт” мэдэгдэлд “ялгаварлан гадуурхалт, түүний дотор үг хэлээр заналхийлэх, үзэн ядах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн цогц үндсийг бүрдүүлэх”, “ийм гэмт хэрэг үйлдэгчдэд хуулийн хариуцлага ноогдуулах талаар зохих арга хэмжээг авах”, “бэлгийн цөөнх гэх мэт эмзэг олон нийтийн хамгааллыг хангах”, “Жогжакартагийн зарчимд заасанчлан бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээс үүдэн заналхийлэх, халдах аливаа үйлдлийг нягт нямбай, түргэн шуурхай, шударгаар мөрдөн шалгах үр дүнтэй бодлого, эрх зүйн үндэс, арга механизмыг бүрдүүлэх” хийгээд “арьсны өнгө, үндэс угсаа болон бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг түрхирах, өөгшүүлж буй байгууллагуудын хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийг батлан гаргах” зөвлөмжийг Монгол улсад өгчээ.

2014 онд хүний эрхийн чиглэлээр ажилладаг 40 орчим иргэний нийгмийн байгууллагыг багтаасан Хүний эрхийн форумаас Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс өгсөн зөвлөмжийг Монгол Улс хэрхэн хэрэгжүүлж байгаад үнэлгээ хийсэн. Уг үнэлгээний урьдчилсан дүнгээс харахад ЛГБТ эрхтэй холбоотой долоон зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Ийнхүү, сүүлийн жилүүдэд ЛГБТ эрхийн асуудалд Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (ХЭТБЭНХ, 2010), ЭЯГБХУК (2008), ЭШЭК (2010) болон ХЭЗ (2011) зэрэг олон улсын хүний эрхийн механизмын хүрээнд хууль тогтоомж, бодит байдалд удаа дараа үнэлгээ, дүгнэлт өгөх зэргээр анхаарал хандуулж, багагүй ахиц дэвшил гарч байна. Энэ бүх үйл явцад ЛГБТ төв чухал үүрэг гүйцэтгэжээ.



## МОНГОЛЫН ЛГБТ АСУУДЛААРХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Үндсэн хууль (1992) нь “...үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал үүсэл ба байдал, өв хөрөнгө, мэрэгжил ба албан тушаал, үзэл бодол ба боловсролоор нь” ялгаварлан гадуурхахаас хамгаалах хийгээд иргэдийн бүх талын эрхийг хангах үндсийг бүрдүүлсэн (14 дүгээр зүйл). Гэхдээ БЧБХБИ-ээр ялгаварлан гадуурхахыг хориглоно гэсэн тодорхой заалт байхгүй. ЛГБТ хүмүүсийг ялгаварлан гадуурхахаас зориуд хамгаалахын тулд дээрх зүйлд “буюу бусад үндэслэлээр” гэсэн нээлттэй агуулгыг нэмж тусгах нь чухал бөгөөд нийгмийн хурдацтай өөрчлөлттэй нийцүүлэхэд хэрэгтэй юм.

Монгол Улсын Үндсэн хуулинд “Эрэгтэй эмэгтэйчүүд улс төр, эдийн засаг, нийгэм ба соёлын хүрээнд мөн гэр бүлийн хэрэгт адил тэгш эрхтэй. Хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй ба эмэгтэй тэгш, харилцан зөвшөөрсний үндсэн дээр гэр бүл болно” (16.11 дүгээр зүйл) гэж заасан. Энэхүү зүйл болон Гэр бүлийн тухай хуулийн (1999) 3.1.1. дэх заалтаар эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн хоорондын нэгдлийг гэр бүл гэж тодорхойлсон нь ижил хүйсийн хүмүүсийн гэрлэлтийг үндсэндээ хориглож байгаа хэрэг юм. Практикт ижил хүйсийн хос хүүхэд үрчлэн авахад эдгээр хууль хориг саад болдог.

Трансжендэр хүмүүс иргэний бүртгэлийн баримт бичигт хүйсийн шилжилтээ тэмдэглүүлэхэд эрх зүйн хувьд саадгүй болсон. Иргэний бүртгэлийн тухай хуулийн 20 (1) дэх зүйлд эмнэлгийн магадлагааг үндэслэн төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэхэд хүйсийн шилжилтийг бүртгэж болох тухай заасан. Энэ нь хүйсийн баримжаа илэрхийллийг хүлээн зөвшөөрөхөд гарсан чухал өөрчлөлт юм.

Үзэн ядах гэмт хэргийг Монголд одоогийн байдлаар гэмт хэрэг гэж үздэггүй. Эрүүгийн хуулин дахь хүчингийн хэргийн тухай заалтад (126 дугаар зүйл) хүйс заагаагүй. Гэвч практикт эрэгтэй хүний эсрэг үйлдсэн хүчингийн хэрэгт энэ заалтыг бус, “бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах” гэсэн 125 дугаар зүйлийг хэрэглэх явдал гардаг. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулинд гэр бүлийг уламжлалт явцуу ойлголтын хүрээнд авч үзсэн нь ижил хүйсийн хүмүүсийн гэр бүлийн хүчирхийллийг орхигдуулж, ижил хүйсийн хос, гэр бүлийнхээ ЛГБТ гишүүний эсрэг хүчирхийлэл үйлдэгч гэм зэмгүй өнгөрөх боломж олгож байна. Хуулинд албан ёсны бүртгэлгүй эсрэг хүйсийн хамтран амьдрагчдыг хамааруулсан ч энэ нь ижил хүйсийн хүмүүсийн харьцаанд хамаарахааргүй байна.

Хууль тогтоомжид ЛГБТ эрхийн асуудлаар учир дутагдалтай зүйл олон байгаа ч Монгол улсад эрх зүйн томоохон шинэчлэл явагдаж байна. Хүний эрхтэй холбоотой олон хууль төслийн шатандаа байгаа эсвэл сүүлийн хоёр жилд УИХ-аар батлагдсан байна. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль 2011 онд батлагдсан, мөн ХДХВ ба ДОХ-ын тухай хууль 2012 онд шинэчлэгдсэн. ХДХВ ба ДОХ-ын тухай хуулиар (2012) ялгаварлан гадуурхах болон залхаан цээрлүүлэх заалтуудыг хасаж, ХДХВ-ын халдвартай хүмүүсийн хувийн асуудал ба нууцлалыг хамгаалсан нь эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэхэд томоохон дэвшил болжээ.

Гэмт хэргийн тухай хуулийн төслийг 2014 оны 4 дүгээр сард УИХ-д өргөн барьсан. Энэ төсөлд анх удаа үзэн ядалтаас үүдэлтэй хэргийг гэмт хэрэг гэж үзэхээр заасан байна. (10 (1) дүгээр зүйл). Тус хуулийн төсөлд хүчинг аль ч хүйсийн хүний эсрэг үйлдэгдсэн байж болохоор тодорхойлсон (12 (1) дүгээр зүйл); мөн гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нь гэр бүлийн харилцаатай хэн нэгэн байж болохоор заасан (11 (7) дугаар зүйл). Хамгийн чухал нь, уг төсөлд бусад үндэслэлийн хамт гадаад төрх, эрүүл мэндийн байдал, БЧБХБИ-ээр ялгаварлан гадуурхахыг хориглосон (14 (1) дүгээр зүйл) явдал юм. Эдгээр өөрчлөлт батлагдвал хэрэгжилтийн явцад сорилт бэрхшээл гарах ч ЛГБТ хүмүүсийг үзэн ядах гэмт хэрэг, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас хуулиар хамгаалах болно. Харин тус хуулийн төсөлд биеэ үнэлэх явдал хууль бус хэвээр байна.

Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн төслийг 2014 оны 5 дугаар сард УИХ-д өргөн барьсан бөгөөд уг төсөлд “хамтран амьдрагч”, цаашилбал гэр бүлийн харилцаатай этгээдийг оруулснаар хуульд хамрагдах хүмүүсийн хүрээг өргөтгөсөн. Уг төслөөр анх удаа гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар төрийн байгууллагуудад тодорхой үүргийг оноон хариуцуулсан байна.

Эцэст нь, Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн төсөл УИХ-д энэ оны эцсээр өргөн баригдах гэж байгаа бөгөөд хөдөлмөрийн харилцаанд бусад үндэслэлийн зэрэгцээ бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахыг хориглох тухай заалт орсон байна.

Эдгээр бүх өөрчлөлт сайшаалтай, гэхдээ ЛГБТ хүмүүсийн эрхийг хангахад хууль эрх зүйн хүрээнд цаашид авч үзэх асуудал бий. Жишээ нь, 2014 оны 6 дугаар сард УИХ-д өргөн барьсан Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн төсөлд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой асуудлыг авч үзээгүй байна. Уг төсөлд гэрлэлтийг эрэгтэй эмэгтэй хүний нэгдэл гэж үзсэн тодорхойлолт хэвээр байна.

Ерөнхийдөө, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид ЛГБТ хүмүүсийг ялгаварлан гадуурхдаггүй ч бас тодорхой дурдсан хамгаалалт тусгагдаагүй. Хэд хэдэн хуулийн шинэчилсэн төсөлд эрхийн асуудлыг өргөн утгаар авч үзэх талаар зохих өөрчлөлт тусгагдаад байна. Хууль эрх зүйн хүрээнд гарч буй нааштай өөрчлөлт нь ЛГБТ хүмүүс эрх нь зөрчигдсөн тохиолдолд хуулиар хамгаалуулахад дөхөм болох юм. Сүүлийн жилүүдэд хийгдсэн эдгээр өөрчлөлт нь урьд өмнө байсан ЛГБТ хүмүүсийн эрх зүйн байдалтай харьцуулахад ахиц дэвшил гарсныг илтгэж байна.



## БҮТЭЦ ТОГТОЛЦООНЫ ОРЧИН

ЛГБТ хүний эрхтэй холбоотой сэтгэл зовоож буй нэг асуудал нь дээрх хууль тогтоомжийн төсөлд тусгагдсан ЛГБТ хүний эрхийг хамгаалахад чиглэсэн өөрчлөлтийг холбогдох байгууллага амьдралд бодитой хэрэгжүүлж чадах эсэх тухай асуудал юм. ЛГБТ эрхийг хамгаалахад чиглэсэн хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хууль сахиулах бүтэц тогтолцоо, хүрч үйлчлэх чадавхи шаардлагатай билээ.

203 онд Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг улс орны хүний эрхийн нөхцөл байдлыг засгийн газрын байгууллага, шүүх, хувийн хэвшил, ХЭҮК, судалгааны хүрээлэн зэргийн оролцоотойгоор үнэлж үзсэний үндсэн дээр боловсруулж, УИХ-аас баталсан. Уг хөтөлбөрт ЛГБТ хүмүүсийн талаар тусгайлан дурдаагүй ч “ялгаварлан гадуурхах ба алагчлах хандлагыг өөрчлөхөд чиглэсэн үхүүлгэ сурталчилгааг олон нийтэд байнга явуулж байхаар” заасан (2.4.6.2). 2011 онд Хууль зүйн яамнаас уг хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлгээ хийсэн бөгөөд зөвлөмжид ялгаварлан гадуурхах хандлагыг өөрчлөх чиглэлээр олон нийтийн дунд үхүүлгэ сурталчилгааг тогтмол хийхийг ялангуяа гол хэрэгжүүлэгчдийн нэг болох ХЭҮК-д зөвлөмж болгожээ (Хууль зүйн яам, 2011).

2011 оны 5 дугаар сард Монгол Улсын Засгийн газрын 159 тоот тогтоолоор НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн зөвлөмжийг 2011-2014 онд хэрэгжүүлэх Ажлын төлөвлөгөөг баталж, түүнд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээс үүдэн ялгаварлан гадуурхахыг хориглосон хууль тогтоомж боловсруулан хэрэгжүүлэх тухай дурджээ. Гэвч дээр өгүүлсэнчлэн одоогоор энэ асуудал хэлэлцэгдэх шатандаа байна. 2013 оны 7 дугаар сард УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос ЛГБТ хүний эрх зөрчигдөж байгаа талаар дурдсан 13 тоот тогтоолыг баталж, түүнд ХЭТТХ-аас өгсөн зөвлөмж, түүний дотор, БЧБХБИ-ээс үүдэн ялгаварлан гадуурхахын эсрэг асуудлыг цогцоор тусгасан хууль тогтоомж батлан мөрдүүлэх; ЛГБТ хүмүүсийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийг шударгаар мөрдөн шалгах зэргийг зөвлөмжийг хэрэгжүүлэхийг даалгажээ.

2001 онд байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалах талаар тууштай ажиллаж ирсэн. Сүүлийн хоёр жилийн хугацаанд ХЭҮК ЛГБТ эрхийн зөрчилтэй холбоотой гомдол хүлээн авсан бөгөөд хуулийн төсөлд хүний эрхийн талаас нь саналаа өгч байна. ХЭҮК-оос жил бүр гаргадаг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь удаагийн илтгэлд (2013) ЛГБТ хүмүүст тулгарч буй хүний эрхийн асуудлыг онцлон тусгажээ. Энэхүү илтгэл нь төрийн байгууллага анх удаа ЛГБТ хүмүүсийн эрхийн асуудалд олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн хүрээнд дүн шинжилгээ хийснээрээ чухал үйл явдал болсон юм. Хүний эрхийг дэмжих чиг үүргийнхээ хүрээнд ХЭҮК-оос төв, орон нутгийн төрийн байгууллагын ажилтнуудад хүний эрхийн сургалт явуулдаг ба сүүлийн жилүүдэд сургалтандаа ЛГБТ хүмүүсийн эрхийн асуудлыг оруулдаг болжээ. ХЭҮК-ын судалгаанд дурдсанчлан, төрийн албан хаагчдын дийлэнх нь ЛГБТ эрхийн асуудлаар сайн ойлголтогтой байдаг.

Хэдийгээр системтэй биш ч цагдаагийн ажилтнууд үндэслэлгүй баривчлах, гудамж талбайд дарамтлах, халдах зэргээр эрх мэдлээ хэтрүүлэх тохиолдол гардаг талаар судалгаанд дурдсан байдаг. 2012 оны нэг судалгаанд гей, бисексуал, трансжендэр хүмүүсийн ихэнх нь (77.4%) өмнөх 3 жилд ямар нэг хэлбэрийн доромжлолд өртсөн тухай дурджээ (Strömdahl et al, 2013). Улаанбаатарт судалгаанд хамрагдсан ЭБЭ хүмүүсийн долоо орчим хувь нь хууль сахиулагчдын сүрдүүлэгт өртөж байсан гэж хариулжээ (Paitzmeier et al, 2014).

“Нэг өдөр миний хэдэн найзууд эмэгтэй хүний хувцас өмссөн трансжендэр хүнтэй хамт гудамжаар явж байсан юм. Гэтэл хэдэн цагдаа гарч ирээд, тэднийг шалгаж, иргэний үнэмлэхээ үзүүлэхийг шаардсан. Тэд нар трансжендэр охиныг маш ихээр гутаан доромжилж, бусдыг нь яагаа ч үгүй, харин тэдэнд “Хүүе энэ бол эр хүн. Энэ нөхөртэй та нар юу хийж байгаа юм бэ? Арай эмэгтэй хүн гэж бодоод байгаа юм биш биз дээ? Энэ ой гутам хүнээс хол байсан нь дээр шүү” гэсэн (Лей нар, 2013).

ЛГБТ хүний эсрэг үйлдэгдсэн хүчин буюу бэлгийн хүчирхийллийг мөрдөн шалгаагүй орхисон тохиолдол гарч байсан байна. Түүнчлэн ЛГБТ хүмүүс хэрэг үйлдэгч хариу авахаас эмээх юмуу таагүй ханддаг хууль сахиулагчдын хариу үйлдлээс айсандаа доромжлол, хүчирхийлэлд өртсөн тухайгаа мэдэгдэхээс эмээдэг ажээ. Жишээ нь, гей залуу тодорхой эзэн (ЛГБТ биш) бүхий хэргийг мэдэгдэхэд цагдаа эргээд уг хохирогч эсвэл өөр гей, трансжендэр хүмүүст л анхаарлаа хандуулж, тэр хэргийг үйлдсэн байж болзошгүй гэж үзжээ. ЛГБТ олон нийтийн нэгэн гишүүн,

“Долоо найман жилийн өмнө Л гэдэг гей дөрвөн хүнд хүчиндүүлж амиа алдсан. Дөрвөн гетеросекс нөхөр согтуугаар энэ хэргийг үйлдсэн. Гэтэл бид бүгдийг [гей эрчүүдийг] нэг давхраас хоёр давхар хүртэл жагсааж байгаад байцааж байсныг” санаж байна гэжээ (Paitzmeier et al, 2014).

Хуулийн хүрээнд эрхээ хэрхэн нөхөн сэргээлгэх нь тодорхойгүй, мөн тодорхой эрсдэл тулгарахаар байдаг тул ЛГБТ хүмүүс хөөцөлдөлгүй орхидог. ЛГБТ олон нийтийн нэг төлөөлөгч “... яагаад гэвэл хуулийн зүйл заалт байхгүй, яагаад гэвэл бидэнд хамгаалалт байхгүй, яагаад гэвэл бидэнд хандах газар байхгүй тул бид хохирогч болоод л үлддэг” гэж гомдлоо илэрхийлсэн байна (Лай нар, 2013). Иймээс хууль эрх зүйн орчныг сайжруулахын зэрэгцээ ЛГБТ эрхийг бодит амьдрал дээр хүндэтгэн сахидаг болохын тулд хууль сахиулагчдад ЛГБТ эрхийн талаар таниулах, ЛГБТ эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр ажиллаж буй төр, төрийн бус байгууллагын чадавхийг системтэй бэхжүүлэх шаардлагатай.



## СОЁЛ БА НИЙГМИЙН ОРЧИН

Монголын гэр бүлийн бүтэц, харилцаанд уламжлалт, эцгийн эрхэт ёсны хэм хэмжээ чухал байр суурь эзэлж байдаг. Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүний шинж чанарыг агуулсан жендэрийн тогтсон үүргийг оноож байдаг бөгөөд ЛГБТ хүмүүст хандах нийгмийн хандлагад нөлөөлөхийн зэрэгцээ бэлгийн чиг баримжаанаас үл хамааран жендэрээс үүдэлтэй хүчирхийллийн нэг нийтлэг шалтгаан болдог. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн жендэрийн үүрэг аажим өөрчлөгдөн, дэвшил гарч байгаа ч эрэгтэй, эмэгтэй хос, хүүхэд өсгөхөд төвлөрсөн уламжлалт хандлага хадгалагдсан хэвээр байна. Гэр бүлийнхний зүгээс хань бүлтэй болохыг шахах нь Монгол залуу хүмүүст тулгардаг нийтлэг асуудал бөгөөд ЛГБТ хүмүүст байнга тохиолддог хүндрэлтэй асуудлын нэг юм.

Ажлын байран дахь ЛГБТ хүмүүст хандах нийгмийн хандлага ихэнхдээ сөрөг бөгөөд таагүй талдаа байдаг. Саяхны нэг судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын дийлэнх нь (64%) тэдний ойр дотны болон таньж мэдэх хүмүүс ЛГБТ хүмүүст “таагүй” буюу “нэн таагүй” ханддаг гэж хариулжээ. Тэдний гуравны нэг нь л ЛГБТ хүмүүст “хэвийн”, “сайн” ханддаг гэжээ. Сөрөг хандлага давамгайлж байсан ч санал асуулгад оролцогчдын нилээд олон нь буюу 46.7% нь хүн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээ сонгох боломжгүй гэсэн бол бас нилээд олон нь (45%) мэдэхгүй гэжээ. Зөвхөн 8.3% нь л ЛГБТ хүмүүс бэлгийн чиг баримжаагаа сонгож болно гэж боддогоо илэрхийлжээ (ХЭҮК, 2013).

Монголд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлд хандах нийгмийн хандлагад шашин нэг их нөлөө үзүүлдэггүй. 2010 оны судалгаагаар, Монголчуудын 61 хувь нь шашин шүтдэг, 39 хувь нь шашин шүтдэггүй гэсэн дүн гарчээ. 15-аас дээш насны шашин шүтдэг хүмүүсийн 53 орчим хувь нь Буддын шашныг шүтдэг (ҮСХ, 2010). Монголын Буддын шашны тэргүүн, лам нарын зүгээс бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой асуудлаар хатуу байр суурь баримталдаггүй. Ерөнхийдөө, Буддын шашин ЛГБТ хүмүүст хүлээцтэй ханддаг, сургааль ном, ёс жаягтаа харш гэж үздэггүй. Христийн шашин ЛГБТ хүмүүст хандах хандлагад мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй.

ЛГБТ олон нийтийн нэг идэвхтний дурдсанчлан үндсэрхэг үзэл нь “... олон нийт, ялангуяа хэт үндсэрхэгчдийн зүгээс ялгаварлан гадуурхах, хавчин шахах явдлыг дэвэргэхэд” хүргэж болзошгүй юм (Nyamdorj, 2010). Тэдгээр бүлэглэлээс ЛГБТ хүмүүсийг заналхийлэх, хүчирхийлэх явдал гарч байжээ.

“2009 оноос Э, Х, Б нэрээр олон нийтэд ил гарч ирсэн транс охидыг ... оршуулгын газар руу аваачиж, онц ноцтойгоор бие эрхтэнд нь халдаж, тамлаж, хүчээр бэлэг эрхтнээ хөхүүлж, мөн охидыг бие биенийхээ бэлэг эрхтнийг хөхөхийг шаардаж, нэгнийх нь шулуун гэдсэнд ууттай чулуу чихэж хүчиндсэн бусармаг явдал гарсан. Энэ талаар ЛГБТ Төвийн “Эрх чөлөөний худал хуурмаг” баримтат кинонд ярьснаас нь болж тэднийг харсан газраа ална хэмээн заналхийлж улмаар ЛГБТ Төв ТББ-ынхны тусламжтайгаар Э, Х нар эх орноо орхин дүрвэн гарсан” (ЛГБТ Төв, 2012).

Олон ЛГБТ хүн Монголын нийгэм дэх гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах хандлагаас үүдэн хүчирхийллийн золиос болох вий гэж эмээж явдгаа илэрхийлдэг. Олон нийтийн нэг төлөөлөгч,

“Би олон нийтийн газар, олон хүмүүсийн дунд чөлөөтэй байж, тайван алхахаасаа үргэлж айдаг. ‘Хэн нэгэн хүн араас тоосго шидэх болов уу, ямар нэг юм над руу чулууудах вий’ гэсэн бодол үргэлж салдаггүй. Иймээс хүмүүстэй ойр зэрэгцэж явахаас байнга зайлсхийдэг. Хүмүүстэй ойр явахад аймаар байдаг” (Лей нар, 2013)

гэсэн бол өөр нэгэн,

“Би хувьдаа хэцүүхэн байдалтай хоёр ба түүнээс ч олон удаа тулгарч байсан. Транс хүмүүс бидний хувьд өөрсдийнхөөрөө байж, охидын хувцас өмсөөд алхахыг хүсдэг. Тэр үед хүмүүс биднийг үг хэлээр доромжлох ... гэх мэтээр аймшигтай хандаж байсан” гэжээ (Лей нар, 2013).

Өөр нэг тохиолдлыг дор дурдав:

“Манай хэдэн найзууд диско клубт бүжиглэж байгаад, намайг ажлаа тараад ирээч гэж дуудсан юм. Намайг очиход хаалга нь түгжээтэй байсан. Хаалгыг нь тогшиход хамгаалагч онгойлгож өгсөн. Би найзуудыгаа дотор байгаа гэж хэлээд орохыг хүсэхэд тэрээр “ За хурдан ор. Тэнд хэдэн гей нөхдүүд байгаа, тэднийг хэрхэн бүжиглэхийг хармаар байна” гэсэн. Тэгээд тэр тэнд байсан хамгаалагчдыг бүгдийг нь цуглуулаад дотор байгаа гей залуусын талаар хэлсэн. Мөн өөр эрчүүдийг авчирч, гей залуусыг дээрэлхүүлье, эр хүний нэр төрийг гутааж байдаг гейүүдийн бөгс рүү нь өшиглөхийг хүсч байна гэж тэр хэлсэн юм... Тэнд би гей залуусыг тэд хэрхэн доромжилж, бусдыг дуудан доромжлуулах гэж байгааг харсан” (Лей нар, 2013).

ЛГБТ хүмүүст хандах нийгмийн хандлагад уламжлал, шашны хүчтэй нөлөө байхгүй тул хүний эрхийн боловсрол олгох ажлын хүрээнд ЛГБТ эрхийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх нь олон нийтийн санаа бодол, хандлагыг өөрчлөх гол арга зам байж болох юм.

Нэгэн ЛГБТ эрхийн талаар ажилладаг нэг төлөөлөгч Үндэсний хэлэлцүүлэг дээр “Өнгөрсөн хэдэн жил би олон сургалт явуулсан, энэ хугацаанд сургалтанд суусныхаа дараа ЛГБТ эрхийг үгүйсгэсэн хэвээр үлдсэн хүн нэг ч тааралдаагүй” гэсэн юм. Энэ нь Монгол дахь ЛГБТ хүмүүсийн эсрэг урьдчилан бүрдүүлсэн төсөөлөл, нийгмийн ялгаварлан гадуурхалтыг зогсоох зорилгоор төр, төрийн бус байгууллага, бусад холбогдох талын хамтран ажиллах нэг чиглэл гэдгийг харуулж байна.





# ЛГБТ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ НЬ

Энэ бүлэгт Үндэсний хэлэлцүүлгийн үр дүн, судалгааны тайлан, ярилцлагын материалд тулгуурлан, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, боловсрол, гэр бүл, хэвлэл мэдээлэл гэсэн чиглэлээр Монголын ЛГБТ хүмүүст тулгарч буй асуудал, мөн ЛГБТ байгууллагуудын чадавхийн талаар танилцуулах болно.



## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Монголын эдийн засгийн өсөлт дэлхийд өндөрт тооцогдож (2013 онд ДНБ-ний өсөлт 11.7%) байгаа ч ядуурал өндөр, хүн амын 27 орчим хувь нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур түвшинд амьдарч байна (ҮСХ, 2013). Саяхны нэг судалгаанд ЛГБТ хүмүүсийн дунд ажилгүйдэл 10.4 хувь байгаа нь 2013 оны улсын дундаж болох 7.8 хувиас өндөр байгааг дурджээ (Отгонбаатар нар, 2014). Судалгаанд оролцогчдын тал орчим хувь (46.2%) нь ядуурал тэдэнд онцгой нөлөөлөөгүй, өөрөөр хэлбэл, ЛГБТ болон гетеросексуал хүмүүст адил тусч байгаа гэсэн байна. Арай өргөн түүвэр бүхий өөр судалгаанд Монголд гей хүн өөрийгөө ил мэдэгдвэл ажил олдохгүй байх эрсдэлтэй гэдгийг ЛГБТ хүмүүс онцлон дурдсан байна (ХӨСҮТ, ДОХ-ын нэгдсэн хөтөлбөр, ЖХНЭМС, 2012). Мөн ийнхүү ил мэдэгдвэл ядууралд орох магадлал хоёр дахин нэмэгдэнэ гэж судалгаанд оролцогчид үзжээ (Отгонбаатар нар, 2014). Сүүлийн үед эдийн засаг удааширсан нь хөдөлмөрийн зах зээлд нөлөөлж, улмаар ЛГБТ олон нийтэд сөргөөр тусч болох талтай.

Монголд ажлын байранд ЛГБТ хүмүүсийг ялгаварлан гадуурхаж байгаа нь ноцтой асуудал юм. Доромжлол, ялгаварлан гадуурхлын асуудал нь ажил олоход гардаг бэрхшээлээс эхлээд дарамтлуулах, дээрэлхүүлэх, гадуурхагдах, тодорхой шалтгаангүй ажлаас халагдах зэрэг янз бүрийн хэлбэрээр илэрдэг. Хөдөлмөрийн тухай хуулийн 7 (2) дугаар зүйлд “үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал байдал, баян ядуу, шашин шүтлэг ба

үзэл бодлоор ялгаварлан гадуурхах, давуу ба хязгаарлагдмал байдал олгохыг хориглоно” гэж заасан байдаг. Өргөн үтгээр нь авч үзвэл, энэ заалтыг ЛГБТ байдлаас үүдэн ажлаас халагдахаас сэргийлэхэд хэрэглэж болохоор байгаа ч шүүхэд хандсан тохиолдол гараагүй байна. БЧБХБИ-ийн талаар ийнхүү тодорхой заагаагүй байгаа нь хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг шинэчилж буй энэ цаг үед хэлэлцэгдэж буй нэг сэдэв юм. Үндсэн хуулийн 16 (4) дугаар зүйлд ажил хөдөлмөрөө чөлөөтэй сонгох эрхийг баталгаажуулсан ч ялгаварлан гадуурхалт түгээмэл байгаагаас бодит байдал дээр хэрэгжиж чадахгүй байгаа нь гадаад төрхөө далдлах боломж хомс трансжендэр хүмүүст нөлөөлсөөр байна. Ажлын байран дээр өдөр тутам тулгардаг ялгаварлан гадуурхалт нь Монгол дахь ЛГБТ хүмүүст тулгарч буй хүний эрхийн хоёр дахь ноцтой зөрчил (16.7%) болохын зэрэгцээ давтамжийн хувьд хууль зүйн туслалцаа авах асуудлын дараа орох түгээмэл (22.2%) тулгардаг бэрхшээл гэж үзэж байна (Лей нар, 2013).

Ажлын байран дээр ЛГБТ хүмүүст учирч буй нэг томоохон асуудал нь гадуурхагдах, ажлаа алдахаас эмээж бодит байдлаа нүүж явдгаас үүдсэн сэтгэлийн дарамт, зовнил юм. “Азид ЛГБТ байх нь” санаачилгын хүрээнд нийтлэгдсэн бусад орны тайланд дурдсанчлан, ийм дарамт нь ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлдөг. Монголд ЛГБТ хүмүүс голдуу нууцлаг байдаг болохоор байнгын ажилтай ЛГБТ хүмүүсийн ихэнх нь ийм зовиуртай явдаг байх талтай. Саяхан хийсэн судалгаагаар бэлгийн чиг баримжаанаасаа үүдэн ажлын байрандаа гадуурхагддаг эсэх талаар асуухад 81.7% нь бодит байдлаа нуун далдалж явдаг гэж хариулсан байна. 11.7% нь хамт ажиллагчид нь тэдний ЛГБТ гэдгийг мэднэ гэсэн бол 3.3% нь ажлын байран дээрээ ямар нэгэн гадуурхалтай тулгарч байгаагүй гэжээ (ХЭҮК, 2013).

Нууц далд байдагтай төстэй өөр нэг асуудал нь ЛГБТ хүмүүстэй хамт ажиллагчдын ихэнх нь тэднийг ганц бие гэж боддог явдал юм. Энэ нь ЛГБТ хүмүүс ижил хүйсийн хамтрагчтай гэдгээ хэлэх боломжгүй байдагтай холбоотой бөгөөд үүнээс үүдээд менежер, хамт ажиллагчид нь ЛГБТ хүмүүсийг илүү цаг ажиллах боломжтой, татлаа түтлээгүй хүмүүс гэж үздэг. Гэр орондоо туслах уламжлалт хандлагын улмаас ажлын газрынхан нь ганц бие гэгдэх хүмүүст гэр бүлтэй, ялангуяа хүүхэдтэй хүмүүстэй харьцуулахад илүү ажил оноодог. Энэ нь ЛГБТ болон гетеросексуал ганц бие хүмүүсийн аль алинд нь хамаардаг асуудал юм.

ЛГБТ хүмүүсийн БЧБХБИ-ийг дарга, хамт ажиллагчид нь мэдвэл ихэнх тохиолдолд асуудал үүсдэг. Хамт ажиллагчид нь гадуурхах, бүр шалтаангүй гэрээг нь цуцлах явдал гардагийг Үндэсний хэлэлцүүлэгт оролцогчид дурдаж байв. Бүлгийн ярилцлагад оролцогч

“Монгол жижигхэн учир нэг ажил олгогчид ЛГБТ гэдгээ хэлэхэд бусад нь мэдээд намайг ажилд авахгүй тохиолдол зөндөө гарч байсан. Нарийн мэргэжлээр сураагүй хүний хажууд би сурчихаад ирсэн байхад тэр хүнийг мэргэжилтнээр ажилд авч байх жишээтэй. Ажлын байран дээр асуудал их гардаг. “Найз охинтой юм уу? Найз охин чинь эрэгтэй байхаа, эр хүн шиг байгаач, яаж яваад байгаа юм, хүүхэн шиг” гэх мэтээр үг хэлээр доромжилдог” (ЛГБТ Төв, 2012).

Мэргэжилтнээр ажилладаг өөр нэг ЛГБТ оролцогч:

“Би дарга, хамт ажилладаг нөхөдтэйгээ сайн харилцаатай, үргэлж талархал хүлээдэг байсан. Гэтэл нэг өдөр тэнд ажиллаад зургаан сар орчим болсны дараа, дарга намайг дуудсан. Тэр над руу ихэд жигшин зөвүүцсэн байдалтай хараад намайг энд ажиллах шаардлагагүй гэж хэлсэн. Яагаад намайг халах болсныг би ойлгоогүй болохоор надад маш гомдолтой байсан. Би ямарч буруу юм хийгээгүй. Дараа нь хэн нэгэн миний бэлгийн амьдралын талаар даргад хэлсэнийг мэдсэн ба энэ нь дараахан нь тухайн

байгууллагад ажил гүйцэтгэж байсан миний хамтран амьдрагчийг энэ байгууллагаас доог тохуу болгон хүндэтгэлгүй харьцах явдал гаргасанаар батлагдсан юм. Нэгэнт би одоо бэлгийн амьдрал болон харилцаагаа нуугаад байхыг хүсэхгүй байгаа болохоор миний ажлын сонголт ямар нэг хэмжээгээр хязгаарлагдсан ба эргэн тойронд дэл сул яриа явсаар л байх юм” гэжээ (Nyamdorj & Garner, 2008).

ЛГБТ гэдгээ ил мэдэгдсэн үед ажил олоход маш бэрхшээлтэй. Ялгаварлан гадуурхалтын улмаас ажилд орох боломж хязгаарлагдмал; ялангуяа трансжендэр хүмүүс гэх мэт гадаад төрхөөрөө илт мэдэгддэг ЛГБТ зарим бүлгийн хүмүүсийг ажил олгогч ялгаварлан үздэг. Зарим трансжендэр хүн биеэ үнэлэх зам руу орж, энэ нь орлого олох ганц эх үүсвэр болох тал ч бий. Биеэ үнэлэх нь Монгол улсад хууль бус тул нэмэлт эрсдэл үүсч, баривчлагдах, торгуулах, эсвэл хоригдох ч боломжтойгоос гадна эрүүл мэндээрээ хохирох, бие махбодийн хүчирхийлэлд өртөх гэх мэт үр дагавар дагуулна. Тэд амьжиргаагаа залгуулахын тулд аргагүйн эрхэнд л биеэ үнэлдэг гэдгийг Хэлэлцүүлэгт оролцсон трансжендэр хүмүүс хэлж байв.

“Трансжендер охидын хөдөлмөр эрхлэлт? Ямар ч боломжгүй зүйл. Хэрэв бид ажилд орж чаддагсан бол яагаад ингэж амьдарна гэж? Бидэнд ингэж бие үнэлж явах шаардлага байхгүй. Хэрэв трансжендэр хүмүүст ажил олддогсон бол бид бүгд л ажиллах байсан. Бидэнд тодорхой түвшний мэдлэг байна. Мэдлэг мэргэжилтэй хүмүүс ажиллах боломжтой л байх ёстой. Гэвч бид хүлээн зөвшөөрөгддөггүй тул ингэж л амьдрахаас өөр арга алга. Монголд биднийг ажилд авна гэдэг боломжгүй асуудал” (Лей нар, 2013).

Манай монголчууд ихэнх нь трансжендэр хүмүүс дуртайдаа л ийм ажил хийдэг гэж боддог, эдийн засгийн аргагүй байдлаас биеэ үнэлж байна гэж ойлгодоггүй тухай Хэлэлцүүлгийн оролцогчид ярьж байв. Ярилцлага өгсөн нэгэн:

“Яагаад гэвэл ялгаварлан гадуурхалтаас болж тэр ажилд орж чаддаггүй болохоор л биеэ үнэлдэг. Хүмүүс үүнийг ойлгодоггүй, дуртайдаа л ийм зүйл хийдэг гэж боддог. Трансжендэр хүмүүс бид цөөхүүлээ тул хамтдаа байж, бие биенээ дэмжих хэрэгтэй. Гэтэл хүмүүс биднийг цугтаа биеэ үнэлцгээж байна гэж үг хэлээр доромжилж, гудамжны охид хүртэл бидэн рүү дайрдаг” гэжээ (Лей нар, 2013).

ЛГБТ олон нийт, ялангуяа трансжендэр хүмүүс эдийн засгийн хувьд эмзэг байдгийн нэг сөрөг үр дагавар нь бэлгийн хүчирхийллийн хохирогч болох эрсдэл юм. Зарим трансжендэр хүн мөнгө олох цөөн аргын нэг болохоор биеэ үнэлэх болдог ба үйлчлүүлэгчдийн дарамт, бие махбодийн хүчирхийлэл амсах нь бараг л өдөр тутам тохиолддог байна (Paitzmeier et al, 2014).

Монгол Улсын Хөдөлмөрийн яам одоо Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж байна. Уг хуулиар ажлын байрны орчин, практикт бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээр ялгаварлан гадуурхахыг зориуд дурдан хориглохыг зорьж байна. Одоо мөрдөгдөж байгаа хуулинд олон үндэслэлээр (үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал болон байдал, баян ядуу, шашин шүтлэг ба үзэл бодлоор) Монголын бүр иргэдийг хамгаалсан заалт бий. Гэвч энэхүү бүх нийтэд хамаатай заалт нь хийсвэр байгаа бөгөөд БЧБХБИ-тэй холбоотойгоор ялгаварлан гадуурхахыг хориглосон заалт орвол ЛГБТ хүмүүсийг ялгаварлан гадуурхаж болохгүй гэдэг нь ажил олгогчдод тодорхой болох юм.



ЛГБТ олон нийтийн төлөөлөгч Г.Нямпүрэв танилцуулга хийв.



## БОЛОВСРОЛ

Монгол Улсын ерөнхий боловсролын тогтолцоо нь бага ангийн 6 жил, дунд ангийн 3 жил, ахлах ангийн 3 жил, нийт 12 жилийн сургалтаас бүрдэх бөгөөд 9 жилийн суурь боловсролыг заавал эзэмших ёстой. Монголын хүн амын тавны нэгийг 15-24 насныхан эзэлж байна (ҮСХ, 2010). Бага сургуульд хамрагдалтын түвшин өндөр, хөвгүүдийн 99.4 хувь, охидын 98.2 хувь нь бага сургуульд суралцдаг. 15-24 насны залуучуудын бичиг үсэгт тайлагдалтын түвшин мөн өндөр, хөвгүүдийнх 94.1 хувь, охидынх 97.6 хувь байна (НҮБХС, 2013). Хүүхэд төлөвших үеэ сургуульд өнгөрүүлдэг болохоор энэ үед бэлгийн боловсрол олгох нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн олон янз байдлын талаар нийтэд зөв ойлголт, хандлага төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой.

1997 онд Эрүүл мэндийн яам, Гэгээрлийн яам (одоо Боловсрол, шинжлэх ухааны яам) бага, дунд сургуульд бэлгийн боловсролын хөтөлбөр нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн. Засгийн газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай (ДЭМБ) хамтран эрүүл мэндийн боловсролын арван гол сэдвийг сонгосоны дотор нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал оржээ. Есдүгээр ангид үзэх хөтөлбөрт аюулгүй бэлгийн харьцаа ба бэлгэвч хэрэглэх; бэлгийн хавьтлыг тэвчих; бэлгийн чиг баримжаа ба илэрхийлэл; бэлгийн харилцаа ба зан үйл; эрсдлийн үнэлгээ; ба аюулгүй бэлгийн харьцаа ба архи зэрэг сэдэв багтсан байна. 1998 оноос БЧБХБИ-ийн асуудал сургалтын хөтөлбөрт орох болсон нь сурагчид эдгээр асуудлыг танин мэдэхэд анхны чухал алхам болжээ (Хүн амын зөвлөл, 2002). ХДХВ ба БЗДХ-аас сэргийлэх асуудлыг багтаасан бэлгийн эрүүл мэндийн боловсрол сургуульд үзэх хөтөлбөрийн нэг гол хэсэг юм. Мөн сурагчид сайн дурын зөвлөгөө, шинжилгээг хэрхэн авч болох талаар мэдээлэл авдаг байна.

Уг хөтөлбөр хэрэгжиж байгаа хэдий ч эдгээр сэдвийг хэрхэн зааж байгаа болон багш нарын чадавхи асуудалтай хэвээр байна. Хэлэлцүүлгийн үеэр оролцогчид багш нар өөрсдөө энэ

талаар наад захын мэдлэггүй, сурагчдад ЛГБТ эрхийн онцлог асуудлын талаар мэдээлэл хүргэж, ярилцаж чаддаггүй талаар хэлж байв.

Сургалтын хөтөлбөрт орсон бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн тухай сэдвийг багш нар голдуу заахгүй орхидог. Судалгаанд хамрагдсан залуу ЛГБТ олон нийтийн төлөөлөгчдийн 10 хувь нь л уг хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн талаар сургуульд байхдаа заалгаж байсан гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдоос БЧБХБИ-ийн талаар буруу ташаа ойлголт авсан хүний эзлэх хувь харьцангуй бага байгаа нь эерэг зүйл юм. Тэдний зөвхөн 1.7 хувь нь л “бэлгийн чиг баримжаа бол сэтгэцийн эмгэг” гэх мэтийн ташаа ойлголтыг зөв гэж үзсэн байжээ (ХЭҮК, 2013).

БЧБХБИ-ийн сэдвийг заах ажил бүтэлгүй байгаа нь сурагчид бэлгийн амьдралын талаар зөв мэдлэг олж авахад нь саад болоод зогсохгүй ЛГБТ сурагчид өөрсдийн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг ойлгож мэдрэхэд тодорхойгүй орчин бий болгож буй хэрэг юм. Тэд ЛГБТ байдлаа ухаарч ойлгоход ихэнхдээ хэцүү байдаг. Эдгээр сэдвийг заах стандарт бий болгохгүй бол энэ асуудлыг танин мэдэх боломж сурагчдад хомс хэвээр байх болно. Энэ байдал нь хүүхэд бусадтай адилгүй гэдгээрээ өөрийгээ зэмлэн буруушаах, мөн өөр байх нь хэвийн зүйл бөгөөд Монголд төдийгүй дэлхийн өнцөг булан бүрт хаа ч байдаг хүн амын тодорхой хэсэг болохыг хүлээн зөвшөөрөхөд нь саад болох билээ. Бусад хүүхдээс өөрийгөө сэтгэл зүйн хувьд тусгаарлах, ганцаардах зэргээс ЛГБТ хүүхэд сэтгэл гутралд автах, амиа хорлох тухай бодох зэрэг асуудалд хүргэх эрсдэлтэй. Мөн сургуульд сурах сонирхолгүй болох, ерөөсөө сурах идэвх буурах зэрэг асуудал гардагийг ХЭҮК-ын судалгаанд дурдсан байдаг.

Амьдрал дээр боловсрол олгож буй байдал хангалтгүй, дээрээс нь нийгмийн гадуурхах үзэгдэл нийтлэг байгаагаас сургуулийн орчин ЛГБТ хүүхэд, ЛГБТ хүмүүсийн хүүхдэд сөрөг уур амьсгалтай, ээлгүй болж байна. Үе тэнгийнхэн, сурган хүмүүжүүлэгчдийн зүгээс ЛГБТ сурагчдыг дээрэлхэх, гадуурхах явдал түгээмэл байдаг. 2013 онд ЛГБТ олон нийтийн дунд явуулсан судалгаанд хамрагдагсдын дөрөвний нэг нь ялгаварлан гадуурхалттай тулгардаг гэжээ. Мөн уг судалгаагаар 6.7% нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл нь өөр гэгдсэнээс болоод сургууль дээр нь дээрэлхэх, биед нь халдах явдал тохиолдож байсан гэжээ (ХЭҮК, 2013). Энэ нь ЛГБТ хүүхэд ахлах ангиасаа сургуулиа орхих явдал ихсэхэд хүргэдэг байна. Үндэсний хэлэлцүүлгийн нэг оролцогч: “Сургууль завсардалт бол боловсролын салбарт ажиллаж буй хүмүүсийн санааг зовоодог асуудал. Гэхдээ сургууль завсардалтын шалтгааны талаар ярихдаа албаны хүмүүс гэр бүлийн амьдралын боломж, санхүүгийн бэрхшээл гэх мэт гагцхүү материалаг талаас нь л ярьдаг. Гэтэл тэнд бэлгийн чиг баримжаанаасаа болон нүд үзүүрлэгдсэний улмаас сургуулиа орхих явдал байдаг. Ялангуяа трансжендер охидын хувьд” гэж ярьсан юм.

Сурагчдыг багш нар нь улаан цайм гадуурхах явдал тохиолддог.

“Сургуулийнхан “Хөөе охин, хүүхээн, гомо энээ тэрээ гэж дуудах бол энгийн л үзэгдэл, бүр барьж аваад алгадаж унагаагаад, элэгдчихгүй л бол юу ч биш. “Энэ юун охин шиг юм” гэж багшийг хэлэхээр ангийнхан пэр хийтэл инээлдээд хамт олных нь дунд эвгүй байдалд оруулж, таагүй орчин үүсгэж байна гэдгээ багш өөрөө мэддэггүй л юм байх даа.” “Шоолуулдгаасаа болоод хичээлээ маш их тасалдаг байсан, бусад гей хүүхдүүд ч сургуулиасаа гарсан зөндөө л тохиолдол байдаг” (ЛГБТ төв, 2012).



Монголын ЛГБТ эцэг эхтэй сурагчид ч ялгаварлан гадуурхагдах, гутаан доромжлогдохын зовлонг амсдаг байна.

“О.Г. нь 38 настай лесбиян. Хамтран амьдрагч эмэгтэйтэйгээ өөрийн ба хамтрагчийнхаа төрүүлсэн 2 хүүхдээ өсгөдөг. 17 настай том охин нь сургууль дээрээ хоёр ээжтэйгээсээ болж ангийнхандаа гадуурхагддаг, ангийнхан нь байнга “Танай ээж чинь гомо биз дээ? Хамт яваад байдаг тэр эгч нь чиний юу юм бэ?” гэх мэтээр янз бүрийн сөрөг хандлага бүхий зүйл түүнээс асууж эвгүй байдалд оруулдаг. “Охиныг минь надаас, миний амьдралаас болж хүмүүс яах бол гэж маш их санаа зовдог. Хамтрагчийн маань төрүүлсэн хүүхэд удахгүй сургуульд орохоор мөн ялгаварлагдана, хүнд байдалд орно гэхээс маш их санаа зовдог” хэмээн ярьж байсан юм” (ЛГБТ төв, 2011, ХЭҮК-ийн илтгэл дэх ишлэл, 2013)

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн шинэ хөтөлбөрийг заах аргыг сайжруулах, багш нарыг сургалтанд хамруулах шаардлагатай байна. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас одоо хүүхэд хөгжиж төлөвших асуудалд түлхүү анхаарч, бүх ангийн хөтөлбөр, заах аргад томоохон шинэчлэл хийгдэж байна. Энэ нь сургуульд бэлгийн боловсролын хичээлийн заах аргыг сайжруулах нэг таатай боломж юм.



## ЭРҮҮЛ МЭНД

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулинд (1998) иргэн бүр эдийн засгийн байдлаасаа үл хамааран эрүүл мэндийн анхан шатны тусламж, эх хүүхдийн тусламжийг үнэ төлбөргүй авахаар заасан байдаг. Анхан шатанд үзүүлж буй тусламжийн бүх зардлыг төрөөс хариуцдаг ба урьдчилан сэргийлэх, өвчний тандалт, халдвар судлалын арга хэмжээ үүнд багтдаг. Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ нь эхийн эрүүл мэнд, хүүхдийн эрүүл мэнд, халдварт өвчин ба халдварт бус өвчин гэсэн эрүүл мэндийн дөрвөн тэргүүлэх чиглэлийг хамарч байдаг. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үндсэн багц нь эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэлт ба эмчилгээг хамрах ба үнэ төлбөргүй. Нэмэлт багц тусламжид хоёр, гурав дахь шатлалын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх болон амбулаторийн тусламж, мөн яаралтай тусламж, урт хугацааны эмчилгээ сувилгаа багтах ба үйлчлүүлэгч төлбөрийн 10-15 хувийг төлдөг. 2010 оны байдлаар Монголын нийт хүн амын 82.6% нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан (ДЭМБ, ЭМЯ, 2012) ба цаашид хамралтын хүрээг өргөжүүлэхийн төлөө ажиллаж байна.

1992 онд ХДХВ-ын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш Монгол Улс ХДХВ-ын бага тархалттай орон хэвээр байгаа бөгөөд тархалтын түвшин 15-49 насны хүн амын 0.03 хувийг эзэлж байна. 2013 оны 12 дугаар сарын байдлаар, нийт ХДХВ-ын халдварын 150 тохиолдол бүртгэгдээд байгаа ба дэлхийн стандартаар тархалт бага гэж тооцогддог. Бүртгэгдсэн ХДХВ-ын тохиолдлын дийлэнх нь эрэгтэйчүүд ба 30-аас дээш насныханд оношлогдсон байна. ХДХВ-ын халдвартай амьдарч байгаа хүмүүсийн 80.7 хувь нь эрэгтэй, тэдний дийлэнх буюу 80 орчим хувь нь өөрсдийгөө ЭБЭ гэж мэдүүлжээ. ЭБЭ дотроос 34 хувь нь бисексуал, 2 хувь нь трансжендэр хүн байна.

Харуулдан тандалт болон тохиодлын судалгаанаас үзэхэд шулуун гэдсээр хамгаалалтгүй хавьтах нь ХДХВ-ын халдвар дамжих гол зам болж байна. Хамгийн сүүлийн харуулдан тандалтын судалгааны дүн хараахан эцэслэж гараагүй байгаа ч тархалтын түвшинг түрүүчийн хоёр судалгааны дүнтэй харьцуулсан дүнгээр Монгол дахь ЭБЭ хүмүүсийн дунд тархалтын түвшин 2011 онд 10.7 хувь (шинжилгээнд хамрагдсан 196 ЭБЭ-ээс 21 нь ХДХВ-



ын халдвартай) байсан бол 2013 онд 14.2 хувь (шинжилгээнд хамрагдсан 255 ЭБЭ-ээс 36 нь ХДХВ-ын халдвартай) болж өссөн байна. Судалгааны энэ дүн албан ёсоор хэвлэгдээгүй байгаа ч анхаарал хандуулах хэрэгтэй болсныг харуулж байна (Глобаль сан, 2014).

ХДХВ ба БЗДХ-ын шинжилгээг олон эмнэлэгт хийдэг ч сайн дурын зөвлөгөө, шинжилгээний цогц үйлчилгээ хүртээмжтэй биш байна. 2014 оны байдлаар нууцлалын хадгалсан ХДХВ-ын шинжилгээ хийх үйлчилгээ үзүүлж буй олон нийтэд тулгуурласан ганц л байгууллага байгаа нь Хамтдаа төв юм. Монголд ХДХВ-ын халдвартай амьдарч буй хүмүүсийн дийлэнх нь ЭБЭ бөгөөд тэд ХДХВ-тэй холбоотой гутаан доромжлол төдийгүй ЛГБТ байдлаас үүдсэн ялгаварлан гадуурхалтад давхар өртөж байгаа нь халдвартай хүмүүс эрүүл мэндийн шаардлага хангасан тусламж үйлчилгээ авахад саад тотгор болж байна. Хэлэлцүүлэгт оролцогчдоос нэр хаяггүй, нууцлалыг хадгалсан ХДХВ, БЗДХ-ын шинжилгээ хийх ЛГБТ хүмүүст ээлтэй эрүүл мэндийн төв, газруудыг өргөжүүлэхийг санал болгосон юм.

ЛГБТ хүмүүсийн дунд сэтгэл гутрал харьцангуй өндөр, өөртөө итгэх итгэл сул байгааг судалгаанд дурджээ (Залуусын дуу хоолойг сонс, 2013). 2012 онд 313 ЭБЭ хүмүүсийн дунд хийсэн судалгаагаар тэдний олонхи нь сүүлийн хоёр жилд наад зах нь хоёр долоо хоногийн турш гутралын шинж тэмдэг илэрч байсан, мөн олонхи нь сэтгэл зүйчийн зөвлөгөө аваагүй гэжээ. Харин тэд голдуу найздаа (38.4%) эсвэл ЭБЭ олон нийтийнхээ нөхдөд (41.2%) хандан тусламж хүсдэг ажээ (ДҮХ, НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөр, ЖХНЭМС, 2012). Уг судалгаагаар ЭБЭ нарын дунд архины хэрэглээ өндөр байгаа нь мөн тогтоогдсон юм. Сэтгэл гутрал, архины хэрэглээ нь ЭБЭ, трансжендэр хүмүүсийн дунд шулуун гэдсээр хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох өндөр эрсдэлт зан үйл рүү түлхдэг. ЛГБТ хүмүүс ичиж зовох, нуугдмал байх нь ХДХВ-ын халдвартай хүмүүстэй ажилладаг ТББ-ууд тэдэнд хүрч үйлчлэх, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх боломжийг хязгаарлаж байна. Нуугдмал байгаа халдвартай хүмүүс нь эмчилгээ авахын оронд эмчилгээгүй явсаар өвчнөө хүндрүүлж, мөн халдвар тарах эрсдлийг нэмэгдүүлдэг.

ЛГБТ олон нийтийн төлөөлөгчид эрүүл мэндийн тусламжийн чанар хангалтгүй, ажилтнуудын хандлага таагүй байдаг талаар өгүүлж байв. Судалгаанд оролцогчдын 70 хувь нь тохиолдож болох хүндрэлээс зайлсхийхийн тулд ЛГБТ байдлаа нуудаг гэсэн бол 10 хувь нь эрүүл мэндийн тусламж авахад маш их хүндрэлтэй, харин тавны нэг нь ямар нэгэн асуудал гардаггүй гэжээ (ХЭҮК, 2013). ЛГБТ байдалтай холбоотой үүсдэг хүндрэлтэй асуудлууд гэвэл "... эрүүл мэндийн тусламж үзүүлэхээс цааргалах (1%), үйлчлүүлэгчийн бэлгийн чиг баримжаа, үйлдэл, хүйсийн баримжаа илэрхийллийг тусламж үзүүлэгч буруутган ярихыг сонсох (5%), сүүлийн гурван жилд авсан эрүүл мэндийн тусламжийн чанарт сэтгэл дундуур байх (1%)" зэрэг дурдагджээ (Paitzmeier et al, 2014). Бэлгийн чиг баримжаагаа нуух нь эрүүл мэндийн тусламж авахад саад учруулж байна. Хэлэлцүүлгийн нэг гей оролцогч,

“Намайг таньж мэдэх хэн нэгэнд хүрчих байх гэж айж эмээдгээс хүн ам цөөтэй хөдөөд эрүүл мэндийн тусламж авахад хэцүү байдаг. Ихэвчлэн би шинжилгээ өгөхөөр хот явдаг, гэхдээ заримдаа замын зардлаа төлж чадахгүй болно” гэсэн юм.

Харин нэг лесбиян оролцогч,

“Намайг эмчид үзүүлэхэд, байнга л ‘Чи эсрэг хүйсийн хүнтэйгээ бэлгийн хавьталд орох хэрэгтэй ш дээ’ гэж хэлдэг байсан. Эмч нар үйлчлүүлэгчийнхээ хувийн асуудлыг огт юман чинээ боддоггүй, хүндэтгэлтэй ханддаггүй нь айдас төрүүлдэг”

гэжээ.

Монголын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүхий л түвшинд ялгаварлан гадуурхах явдал, сөрөг хандлага түгээмэл байгаа нь дорвитой арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна. Ялгаварлан гадуурхалт нь эрүүл мэндийн тусламж үзүүлэгчдэд зохих сургалт явуулахгүй байгаагаас зарим талаар үүдэлтэй. Тэдний олонхи нь бэлгийн цөөнхтэй хэрхэн ажиллах, тэдэнд тулгарч буй онцлог асуудлыг хэрхэн үр дүнтэй шийдвэрлэхийг мэдэхгүй байна. Ерөнхийдөө, ЛГБТ хүмүүсийн хэрэгцээнд тохирсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй байна. Трансжендэр хүмүүсийн хувьд дааврын эмчилгээ, хүйсийн шилжилтийн мэс засал хийлгэх, сэтгэл зүйн зөвлөгөө авах боломж байдаггүй зэрэг онцлог бэрхшээл тулгардаг. Үүний зэрэгцээ эдгээр үйлчилгээний аль нь ч эрүүл мэндийн даатгалд хамрагддаггүй. Хэлэлцүүлгийн трансжендэр эмэгтэй оролцогч,

“Би хэзээ ч эмэгтэй хүний хувьд эрүүл мэндийн тусламж эмчилгээ авч байгаагүй. Би үнэхээр хаана хандахаа мэдэхгүй байна, яагаад гэвэл манай оронд трансжендэр хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээг мэдэх мэргэжилтэн байхгүй. Би дааврын эмчилгээ, мэс засал хийлгэх боломжгүй, яагаад гэвэл эрүүл мэндийн даатгалд хамрагддаггүй болохоор” гэжээ.

Санхүүгийн боломжтой цөөн хүмүүс л Хятад, Тайланд зэрэг оронд очиж эрүүл мэндийн ийм үйлчилгээ авдаг байна.

ЛГБТ хүмүүсийн эрүүл мэндтэй холбоотой бэрхшээлтэй асуудлыг Хэлэлцүүлэгт оролцсон олон хүн хөндөж ярьсан боловч энэ талаар илүү баримттай судалгаа хийх шаардлагатай байна.

Гутаан доромжлолыг зогсоох нь засгийн газраас ойрын үед шийдвэрлэхээр санаа тавьж буй нэг асуудал юм. ЭМЯ-наас 2013 оны 11 дүгээр сард Ёс зүйн шинэ дүрмийг баталж, түүнд ялгаварлан гадуурхахгүй байх заалтыг Үндсэн хуулийн 14(2)-д заасны дагуу дагаж мөрдөхийн зэрэгцээ гадаад төрх; эрүүл мэндийн байдал; бэлгийн чиг баримжаа/хүйсийн баримжаа илэрхийлэл; ба тодорхой бүлгүүдийн онцлог зэргийг хамруулан тодорхойлсон байна. Эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд сургалтыг өргөнөөр явуулах шаардлагатай байна. 2014 онд НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөрөөс зохион байгуулсан хүний эрхийн сургалтыг эрүүл мэндийн тусламж үзүүлэгчид маш эерэгээр хүлээж авсан ба олонхи нь ЛГБТ хүмүүсийн хүний эрхийн талаар болон зан үйлээ хэрхэн өөрчлөх талаар мэдээлэл авах боломж өмнө нь гарч байгаагүй гэж байв. Засгийн газрын байгууллагууд ийм сургалтыг байнгын, системтэй үйл ажиллагаа болгох нь чухал.



## ГЭР БҮЛ

Монголын ЛГБТ хүмүүсийн гэр бүлийн гишүүдийн олонхи нь тэдний талаар сөрөг хэвшмэл ойлголттой байдаг тул ЛГБТ хүмүүсийн олонхи нь мэдэгдэхгүй байхаар шийддэг байна. ЛГБТ олон нийтийн дунд явуулсан судалгаанд оролцогчдын 86.7 хувь нь “Та гэр бүлийнхэндээ урьд өмнө нь ялгаварлан гадуурхагдаж байсан уу?” гэсэн асуултанд тэгнэ гэхээс эмээгээд гэр бүлийнхэндээ мэдэгдээгүй гэж хариулсан байна (ХЭҮК, 2013). Мөн 2012 онд Улаанбаатарт ЭБЭ нарын дунд явуулсан судалгаагаар, 16.5 хувь нь л гэрийнхэндээ бэлгийн чиг баримжаагаа мэдэгдсэн байжээ.

ЛГБТ-ийн талаар гэр бүлийн хүрээнд дутуу дулимаг ойлгодог, дэмжлэг сул байгаа нь ЛГБТ хүмүүсийн амьдрал ахуй, сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Гэр бүлээсээ хөндийрэх (32%), гэр бүлийнхэн нь бөөнөөрөө уулзахдаа оролцуулахгүй байх (43%) зэрэг

явдал ЛГБТ хүмүүст олонтаа тохиолддог (Paitzmeier et al, 2014). Гэрийнхэндээ ил болсон нөхөд нь гэр бүлийн нэр хүнд унагалаа гэсэн зэмлэл хүлээдэг талаар Хэлэлцүүлгийн үеэр оролцогчид ярьж байв. Судалгаанд хариулсан ЛГБТ хүмүүсийн 73.3 хувь нь “нийгмийн зүгээс тэднийг хүлээн зөвшөөрдөггүй, ойлгодоггүй байдлаас болоод” амиа хорлох талаар бодож байсан гэсэн нь сэтгэл сэрдхийлгэсэн баримт юм (ХЭҮК, 2013).

“Нэгэн гей залуу ... эрэгтэйчүүдийн эрхийг хамгаалах зорилгоор байгуулагдаж байсан Тавилан ТББ-ын үүсгэн байгуулагчдын нэг ба ... гей хүмүүсийн эрх зөрчигдөж буй талаар “Сэрүүлэг” сонинд ярилцлага өгснөөсөө болж “Ингээд гомотож яв” хэмээн төрсөн ахдаа хөлөө хугалуулж байсан” (Хувийн архив, МИЛК төвийн баримтжуулалт, 2006, ХЭҮК-ын илтгэл дэх ишлэл, 2013).

ЛГБТ хүмүүс гэрийнхэндээ мэдэгдэж ил гарсан ч гэрийнхнийхээ нүдэнд “хэвийн бус” мэт харагддагаа мэдэрдэг. ЛГБТ харилцааг зарим гэр бүлд ‘гэмт үйлдэл’ ч гэж үздэг.

“Б.П. нь гей залуу ба 2005 оны 4-р сард цагдаагийн газар ажилладаг нагац ах нь түүнийг Бээжинд гадаад эртэй хамт амьдардгийг нь сонсоод гэртээ дуудан авч ирж байгаад бороохойгоор зоджээ. Түүний их бие болон гуя, өгзөг хэсгээр маш их бяцралт үүссэн байна. Тэрээр маргааш нь “Хамаатан садангаа, дээрээс нь цагдаад ажилладаг хүнийг яаж цагдаад өгөх вэ” гээд Монголоос явсан байна” (ЛГБТ Төв, 2012).

“Намайг ингээд л төрчихсөн гэдгийг ойлгохгүй байгаа гэр бүлийнхэнтэйгээ ярихыг хүсдэггүй ч тэднээс санхүүгийн хувьд хараат, бие даан амьдрах боломжгүйгээс өдөр болгон гэртээ орохдоо хөндий хүйтэн, намайг үзэн ядсан мэт хүмүүсийн дунд ордог. Амиа хорлочихвол эд нар уйлах болов уу, намайг алсан гэж бодох болов уу ч гэж хааяа боддог. Жаахан л юм болвол “Гаж донтон” гээд орилоод “Уруу татсан хүнийхээ нэрийг хэл” гэдэг. Гэтэл би ингээд л төрчихсөн, ухаан орохоосоо л ийм байсан гэж хэлээд ойлгодоггүй. “Чамайг төрүүлсэндээ харамсдаг” гэж ээж, ааваасаа сонсох шиг аймаар зүйл байхгүй. “Муу амьд явснаас үхчихээсэй” гэж хоорондоо ярьж байхыг нь ч сонссон. Хааяа дэндүү аймаар санагддаг, амиа ч хорломоор үе зөндөө байсан” (ЛГБТ Төв, 2012).

Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээ илчилсэн эсэхээс үл хамааран ЛГБТ хүмүүст тулгардаг нэг асуудал нь эсрэг хүйсийн хүнтэй гэр бүл болж, хүүхэдтэй болохыг шахдаг явдал юм. Мөн эрэгтэй, эмэгтэй хосоос бүрдэх гэр бүлийн уламжлалт үнэт зүйлсийг үл ойшоож байна гэж үздэг. Монгол гэр бүлийн уламжлалт бүтцийн дагуу, хүмүүс ихэвчлэн хорин хэдэн насандаа гэрлэдэг бөгөөд гэрлэхгүй удвал нэлээд асуудал үүсдэг. Монголд гэрлэлтийн дундаж нас эрэгтэйчүүдийн хувьд 26.2, эмэгтэйчүүдийн хувьд 24.2 байна (ҮСХ, 2011). ЛГБТ хүмүүсийн ихэнх нь эцэг эхдээ хэлээгүй байдаг болохоор тэд гэрлэхийг нь хүлээж байдаг бөгөөд энэ нь сэтгэлийн дарамт, бухимдлын нэг шалтгаан болдог байна. Монголд олон гей залуу, бас магадгүй лесбиан эмэгтэй эсрэг хүйсийн хүнтэйгээ гэрлэж, хоёрдмол амьдралаар амьдарч байна. Тэд эхнэр, нөхөртэйгээ бэлгийн харьцаатай байхын зэрэгцээ ижил хүйсийн хүнтэй нууцаар бэлгийн харьцаатай байдаг. Гей залуучуудын хувьд энэ нь олон хавьтагчтай байх, БЗДХ авах эрсдлийг нэмэгдүүлж байгаа юм. Эсрэг хүйсийн хүнтэй гэрлэсэн ЛГБТ хүмүүс бий гэдэг нь тэд гей гэдгээ ил мэдэгдсэн хүмүүстэй бас бэлгийн харьцаатай байдгаас харагдаж байгаа ч тийм хүн хэр олон байгаа талаар мэдээлэл байхгүй. Ерөнхийдөө, гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалт болон хүчирхийлэл нь ЛГБТ хүмүүс нуугдсаар байхад хүргэж байна.



Оролцогчдыг 6 сэдвээр дэд бүлэгт хуваахын тулд өнгөт зүйлд ашиглав

Монгол Улсын Үндсэн хуулинд эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болохыг л гэрлэлт гэж тодорхойлсон (16 дугаар зүйл) тул ижил хүйсийн болон хүйс заагаагүй гэрлэлтийг хүлээн зөвшөөрдөггүй. Хуулийн энэхүү заалт нь ижил хүйсийн хос эсрэг хүйсийн хосын адил тэгш эрх эдлэхэд саад болж байгаа юм (ХЭҮК, 2013). Гэрлэлтийн тэгш эрх хангагдаагүй тул гэрлэсэн хосод хамаарах эрх, халамж, дэмжлэгийг ижил хүйсийн хосууд хүртдэггүй. Тухайлбал, гэрлэсэн эр эм хос хүүхэд үрчлэн авч болдог. Интерсекс олон нийтийн төлөөлөл болох нэг хүн дараахь асуудлыг хөндсөн байдаг.

“Гэр бүлийн хууль бий. Бид бусадтай адилхан л хүн. Гэтэл энэ хуулиар бид бусад жирийн хүмүүсийн нэгэн адилаар гэрлэж болдоггүй. Хар л даа, би интерсекс болохоор гэрлэх боломжгүй. Өөрөөр хэлбэл [Би хэнтэй ч гэрлэж болохгүй]. Миний хүйсийн илэрхийлэл тодорхой бүс болохоор намайг гэрлэхийг зөршөөрөхгүй” (Лей нар, 2013).

ЛГБТ төрийн бус байгууллагууд ЛГБТ хүмүүсийн гэр бүлийг дэмжих талаар ялангуяа Улаанбаатарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Хамтдаа төвөөс гэр бүлийнхэн, сэтгүүлчдэд зориулсан сургалт зохион байгуулдаг. 2013 оноос Дэмжих төв гэр бүлийнхэнтэй тогтмол уулзалт хийдэг болсон. Зарим гэр бүл эхлээд эсрэг байдаг бол дараа нь үр хүүхдээрээ бахархдаг эцэг эх болж, ЛГБТ хүмүүсийн бусад гэр бүлд тус болохыг хүсдэг. Иймэрхүү уулзалт нь ЛГБТ хүмүүсийн гэр бүлд их дэм болдог бөгөөд уулзалтанд оролцсон олон эцэг эхэд хүүхдийнхээ тухай мэдэхийг хүссэн зүйлээ асуух, ЛГБТ байхын үтга учрыг ойлгож мэдэх боломж энд л олддог ажээ.

Хэдий бэрхшээлтэй ч зарим ЛГБТ хүн гэрийнхэндээ хэлж, гэр бүл нь хүлээн авдаг, гэхдээ ийм явдал ховор тохиолддог. Хэлэлцүүлгийн зарим оролцогч бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээ гэрийнхэндээ хэлснээр өөрөө өсч хөгжих, хэн гэдгээ хүлээн зөвшөөрөх, улмаар гэр бүлийн эерэг харилцаа бүрдэхэд сайнаар нөлөөлсөн гэж байв. Нэг оролцогч энэ талаар,



“Би өөрийнхөө байдлыг ээждээ мэдэгдэхийг хичээж, энэ талын мэдээллийг гэртээ аваачдаг байсан. Энэ тус болоогүй. Өөрийгөө ээждээ хэлж ойлгуулж чадахгүй байгаадаа би сэтгэл зовнидог байв. Тэгээд нэг л өдөр би ‘ээж ээ, хүү чинь гей’ гэж хэлсэн. Энэ ээжид маань хүнд туссан л даа. Бид Дэмжих төвөөс зохион байгуулдаг сургалтанд хамтдаа оролцсон. Сургалтын үеэр ээж маань ихэр татан уйлж, би ч бас дагаад уйлсан. Уулзалтын дараа, мөн эмчтэй ярилцсаны эцэст бид хоёулаа тайвширсан. Одоо би сэтгэл хангалуун байгаа, ээжтэйгээ чөлөөтэй ярилцдаг” гэсэн юм.



## ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

1992 оны Үндсэн хууль батлагдсаны дараа хэвлэл мэдээллийн хэрэгсэл чөлөөтэй, нээлттэй болсон. 2013 оны байдлаар тус улсад 500 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага ажиллаж, тэнд болон чөлөөт сэтгүүлчээр олон хүн ажиллаж байна (Хэвлэлийн хүрээлэн, 2013). Эдгээрээс 60 гаруй хувь нь хэвлэмэл мэдээллийн, бусад нь нэвтрүүлэг, цахим мэдээллийн компаниуд юм. Хэвлэл мэдээллийн зах зээл өргөжсөн ч янз бүрийн үзэл бодлыг тэнцвэртэй илэрхийлэх явдал учир дутагдалтай хэвээр байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар баталгаажсан. Гэвч сэтгүүлчид нийтэд хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар л нийтлэх дарамт шахалттай тулгардаг хэвээр байгаа (Freedom House, 2006) нь ЛГБТ эрхтэй холбоотой асуудлаарх нийтлэлд нөлөөлж буй нэг хүчин зүйл юм. Хэвлэлийн эрх чөлөө байгаа ч сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүй, хариуцлага нь хэвлэл мэдээллийн салбар дахь томоохон асуудал юм. Монголд энтертэймент буюу амралт, цэнгээний хөтөлбөр телевиз, радио, хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл, түүний дотор олон уншигчтай сэтгүүлээр дамждаг бөгөөд эдгээр нь Монгол соёлыг тайлбарлан түгээж буй гол эх сурвалж юм. Сэтгүүл зүйн эдгээр гол хэрэгсэл ЛГБТ асуудлыг аль өнцгөөс таниулах вэ гэдэг нь эрх амьдралд бодитой хэрэгжихэд ихээхэн нөлөөтэй.

Монголд хэвлэл мэдээллийн хэрэгсэл ЛГБТ асуудлыг хэрхэн авч үздэг талаар албан ёсны судалгаа байхгүй тул энд дурдсан зүйлс ихэнхдээ ердийн ажиглалтанд суурилсан болно. Монголд хэвлэл мэдээллийн хэрэгсэл ЛГБТ асуудлыг ерөнхийдөө сөрөг өнгө аясаар дүрсэлдэг бөгөөд хэвлэл мэдээллийн салбарт ажилладаг ЛГБТ хүмүүс ч үүнтэй санал нэгтэй байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч буй ЛГБТ хүмүүсийн талаарх ихэнхи материал аль нэг туйл руу хэлбийсэн байдаг. Зарим нийтлэл, амралт цэнгээний хөтөлбөр эрс шүүмжилсэн аястай, ЛГБТ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхах үзлийг дэвэргэхүйц хандлагатай байдаг бол зарим нь ЛГБТ байх нь гэр бүл, нийгэмд эзлэх байр суурь, хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй нөлөөтэй холбон өрөвдсөн өнгө аясаар ханддаг. Энэ нь ЛГБТ хүмүүсийн талаар сөрөг ойлголт олон нийтэд тархахад хүргэж байна.

Тогтсон нийтлэлийн бодлого бүхий өдөр тутмын сонин, сэтгүүлүүд баримтад тулгуурласан, нухацтай материал үе үе нийтэлдэг ч тэр бүр олныг хамарч хүрдэггүй. 2014 оны эхээр UB Post гэх мэт зарим мэдээллийн хэрэгслээр ЛГБТ эрхийн асуудалд нааштай нөлөө үзүүлэх нэг асуудал болох Эрүүгийн хуульд үзэн ядах гэмт хэргийн тухай заалт оруулах гэж байгаа талаар сурвалжилж байсан билээ. Сүүлийн үед Монгол дахь ЛГБТ эрхийн асуудлаар гадаадын хэвлэл, ялангуяа цахим сонин нэлээд бичих болжээ.

Олны танил хошин шогийн жүжигчид гей эрэгтэйн дүр оруулсан тоглолт үе үе хийдэг ба тоглолтыг дэлгэцээр олон гаргадаг, хүмүүс ч их үздэг. Энэ нь нэг талаар гей хүмүүсийг ил гаргаж, танилцуулж байгаа мэт боловч эм шинжтэй, эсвэл гял цал болсон инээдтэй дүрээр харуулдаг тул гей эрчүүдийн талаарх хэвшмэл сөрөг ойлголтыг давтан, ЛГБТ хүмүүсийг ойлгох, хүлээн зөвшөөрөхөд тус болж чадахгүй байгаа юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр асуудлыг бодитой авч үзэж чадахгүй байгаагийн шалтгаан нь сэтгүүлчдийн хүний эрхийн боловсрол, судалгаа хийх үр чадвар дутмаг, хариуцлага сул, хүний хувийн асуудалд хүндэтгэлтэй хандах арга барил эзэмшээгүй байгаатай холбоотой. Хэлэлцүүлэгт оролцогчид буруу ташаа, цуу мэдээг цацдагаас эхлээд хувийн нүүцлалыг үл хүндэлдэг, хувийн амьдралын нарийн ширийн, зураг зэргийг зөвшөөрөлгүй нийтэлдэг гэх мэт сэтгүүлчид мэргэжлийн түвшинд ажиллахгүй байгаатай холбоотой олон асуудлыг хөндсөн билээ. Цахим мэдээллийн сүлжээнд хувийн зураг зөвшөөрөлгүй тавьж, дамжуулж байгаа нь мөн анхаарал татаж буй асуудал юм.

Ерөнхийд нь авч үзвэл, Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл ЛГБТ асуудлаар сайн ойлголтоггүй байна. Энэ нь ЛГБТ асуудлын талаар үг хэллэг, нэр томъёог буруу хэрэглэж байгаагаас тод харагдана. Харилцаа холбооны зохицуулах газраас (ХХЗГ) ЛГБТ үндсэн нэр томъёо болох ‘гей’, ‘лесбиан’, ‘гомосексуал’ зэрэг үгийг интернетээр хэрэглэхийг хориглосон байна. Энэ нь эдгээр үг Монголын нийгэмд голдуу сөрөг, магадгүй доромжилсон утгатай гэж ойлгогддогийг харуулж байна (Shuud.mn, 2013; Garner, 2014; Tufnell, 2014). Уг хоригийг зөрчвөл торгох, бүр хорьж ч болохоор заасан байна. Иймээс хэвлэл мэдээллийнхнийг сургах, зохих удирдамжаар хангах ажлыг даруй хийх хэрэгтэй байна. Тухайлбал, ЛГБТ олон нийтээс одоо ‘ЛГБТ’ гэдэг нэр томъёог мэдээллийн хэрэгслээр ашиглахыг дэмжин ажиллаж байна.

Зарим үед сэтгүүлчид зөвхөн олны анхаарлыг татах зорилгоор ЛГБТ амьдралын хэв маягийг буруу ташаа, сенсац болгон нийтэлдэг. ЛГБТ олон нийтийн нэг гишүүнд нэгэн цахим сайтаас ЛГБТ хүний эрхийг дэмжих, ЛГБТ асуудлаар олон нийтэд зөв ойлголт өгөх зорилготой гэж хэлээд хүсэлт гарган ярилцлага авчээ. Гэтэл нийтлэгдсэн ярилцлага нь сөрөг ташаа мэдээлэл, зэмлэл, дайралт давшилтаар дүүрэн, гаргахгүй гэсэн хувийн амьдралын асуудлыг нь хүртэл дэлгэсэн ажээ. Түүчнлэн гей эсвэл трансжендэр эмэгтэйн эсрэг үйлдсэн хүчирхийллийн харамсалтай үйл явдлыг мэдээлэхдээ явцуу хэвшмэл ойлголтдоо хөтлөгдөн, тухайн олон нийтийг бүхэлд нь буруутган мэдээлэх явдал гардаг.

“Сэтгүүлчид маш их мушгин гуйвуулдаг нь илт байдаг. Ижил хүйсийн харилцааг гаж дон гээд ойлгочихсон; энэ төсөөллөөсөө цааш гардаггүй; ямар нэгэн судалгаа эрэл хайгуул хийдэггүй ... ийм хүмүүсийн хүний эрхийн талаар ч юм үү эс бөгөөс хууль эрх зүйн талаас нь ч харахыг оролддоггүй. Сэтгүүлчид энэ хүмүүсийг явал бусад хүмүүс хамгийн сайнаар хүлээж авах вэ, яаж тэднийг сөрөг үзэл ойлголтоос хамгаалах талаар санаа тавьдаггүй” (Nyamdorj & Garner, 2008).

ЛГБТ хүмүүсийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ерөнхийдөө сөрөг талаас нь харуулдаг ч зарим нэг нааштай ахиц гарч байна. ЛГБТ төрийн бус байгууллагууд, ХЭҮК-оос бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн асуудлаар сэтгүүлчдэд сургалт явуулах, хэвлэл мэдээллийнхний мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажил хийж байна. 2010 онд ЛГБТ олон нийтийн төлөөлөгчид Монгол телевизийн ЛГБТ эрхийн асуудлаарх ярилцлагад оролцсон ба энэ нэвтрүүлгээр ЛГБТ хүмүүс анх удаа ил гарч, өөрсдийн түүх, ажил төрлийнхээ талаар нээлттэй ярьсан. Үүнээс өмнө нэвтрүүлэг хийхдээ ЛГБТ хүмүүсийг хөшигний цаанаас эсвэл царайг нь харуулдаггүй байсан нь хүмүүст таагүй сэтгэгдэл төрүүлдэг байв. Энэ нэвтрүүлгийн дараа хэд хэдэн телевиз ЛГБТ эрхийн асуудлаар нэвтрүүлэг хийж, ЛГБТ олон нийтийн гишүүд, эрүүл мэндийн ажилтнууд, хуульч, ЛГБТ хүмүүсийн гэр бүлийг урьж оролцуулан, тэдэнд тулгардаг асуудлын талаар ярилцсан. Эдгээр нэвтрүүлэг нь ЛГБТ хүмүүсийн амьдралыг олон өнцгөөс таниулж, үзэгчдэд нарийн мэдрэмжтэй хүргэхийг зорьсон байдаг. 2013 онд Монгол дахь НҮБ-аас ЛГБТ асуудлыг сонин сэтгүүл, цахим мэдээллийн хэрэгсэл, телевизээр бодитой таниулсан сэтгүүлчдэд Бахархал шагнал гардуулсан байна.





## ЛГБТ ОЛОН НИЙТИЙН ХӨГЖИЛ

Монгол дахь ЛГБТ олон нийт сүүлийн хэдэн жилд буюу ЛГБТ ТББ-үүд байгуулагдсанаас хойш л зохион байгуулалтанд орж эхэлжээ. Үйлчилгээ үзүүлэгч ТББ-үүдыг эс тооцвол албан ёсоор байгуулагдсан олон нийтийн хөгжлийн төв, олон нийт цуглах ээлтэй газар байхгүй. ЛГБТ үйлчилгээний газар цөөн, ЛГБТ хүний ажиллуулдаг хүмүүст нилээд танил болсон шөнийн клуб гэх мэт хэдхэн газар л байдаг. ЛГБТ олон нийтээс үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй нэг бэрхшээл нь ЛГБТ хүмүүсийн нөхцөл байдал, байршлын талаар, ялангуяа Улаанбаатараас бусад газрын хувьд, мэдээлэл бараг байхгүй байгаа явдал юм. Гэхдээ саяхнаас хоорондоо харилцах, ажлаа үялдуулах албан бус хэлбэр бий болгох санаачлага гарган ажиллаж эхлээд байна. 2014 оны 4 дүгээр сард Залуус Эрүүл мэнд ТББ-аас санаачлан ЭБЭ хүмүүст зориулсан дотроо гей, трансжендэр эмэгтэйчүүд гэсэн дэд бүлэгтэй цахим хүүдастай болохоор төлөвлөөд байна. ЛГБТ эрхийн асуудлыг цухас авч үздэг ХДХВ-ийн хөтөлбөрүүдийг эс тооцвол олон нийтийн хүчин чармайлтыг зохион байгуулах, зохицуулах асуудал ялангуяа нуугдмал олон нийт болох лесбиян эмэгтэй, трансжендэр эрэгтэйчүүдийн хувьд бүр хязгаарлагдмал байна.

ЛГБТ олон нийтийн амжилттай зохион байгуулсан нэг арга хэмжээ бол 2013 оны 9 дүгээр сард Монголд анх болсон Бахархалын долоо хоног байв. Олон ЛГБТ хүн энэ бол үнэхээр түүхэн бөгөөд сэтгэл хөдлөм арга хэмжээ байсан гэж үздэг. Үндэсний хэлэлцүүлгийн нэг оролцогчийн хэлснээр:

“Итгэл үнэмшил, хүсэл зориг хийгээд ЛГБТ олон нийтийн дэмжлэг, холбоотнууд, төрийн байгууллага, иргэний нийгэм, олон улсын байгууллагууд, бусад оролцогч талууд гээд долоо хоногийн түрш үргэлжилсэн бүхий л арга хэмжээнд оролцсон, хувь нэмрээ оруулсан бүх хүний [оролцсон хэн бүхэн] сэтгэл өндөр байсан”.

Тус долоо хоногийн үеэр нээлтийн ёслол, ‘Хөх тэнгэрийн цаана’ уран бүтээлийн үзэсгэлэн, ‘ЭБЭ-10 жилд’ нээлттэй хэлэлцүүлэг, ЛГБТ эрх, эрүүл мэнд, ил гарах зэрэг сэдвээр бүлгийн хэлэлцүүлэг, Лесбиян ба гей хүмүүсийн найз, эцэг эхчүүд (ЛГНЭ) уулзалт, ‘Хөх тэнгэр’ кино наадам, Супер шоу үзүүлбэр зэрэг олон сонирхолтой арга хэмжээ явагджээ. Бахархалын долоо хоног арга хэмжээ мянга гаруй зочин, олон нийтийн төлөөлөл оролцсон бөгөөд кино наадмын үеэр Монгол, Хонг Конг, Индонези, Филиппин, Испани, Английн киноноос үзүүлсэн байна. Түүнчлэн ‘Кино урлаг ба ЛГБТ эрх’, ‘Илэрхийлэл ба ЛГБТ’, ‘Монголын соёл, олон улсын соёл ба ЛГБТ эрх’ зэрэг олон хэлэлцүүлгийг дэлгэцээр гаргажээ. Мөн олон нийтийн төлөөлөгчид Монгол дахь ЛГБТ хүмүүсийн эрх, эрх чөлөөг хамгаалах талаар НҮБ-аас гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх тухай УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны тогтоолд талархаж байгаагаа илэрхийлсэн байна.

“... Бахархалын долоо хоног ЛГБТ хүмүүсийн эрхийн талаар олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх зорилгодоо хүрлээ, үйл хэрэгт уриалан дуудлаа, хамгийн чухал нь төдийлөн сонсогддоггүй дуу хоолойг сонслоо. ЛГНЭ уулзалтанд оролцсон нэгэн ээж ‘Би хүүгийнхээ эрхийн төлөө тэмцдэг байсан бол одоо харин би Монгол дахь ЛГБТ олон нийтийн эрхийн төлөө тэмцэх болно’ гэж хэлсэн юм” (Ts.Otgonbaatar, 2013).



# ЛГБТ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАДАВХИ

Монголын иргэний нийгэм харьцангуй эрүүл саруул бөгөөд идэвхитэй. Төрийн бус байгууллагуудын тухай хууль 1997 онд батлагдсан. Байгууллагуудын тоо 1990-ээд оны эцэс гэхэд 770 байсан бол Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын (УБЕГ) мэдээгээр өнөөдөр 17000 гаруй болж өсчээ. Эмэгтэйчүүдийн эрх, байгаль орчныг хамгаалах болон хүний эрх гэх мэт янз бүрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг маш олон ТББ-ууд байдаг. Санхүүгийн эх үүсвэрээс хамааран ТББ-уудын чадавхи янз бүр. Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж буй олонхи ТББ-ууд олон улсын санхүүгийн дэмжлэгээс хамааралтай байдаг бөгөөд дотоодын санхүүгийн эх үүсвэр хомс.

ЛГБТ эрхийн асуудлаар ажиллах зорилготой байгууллагуудын тоо цөөхөн. Дөрвөн байгууллага Улаанбаатарт ЛГБТ хүмүүст зориулсан үйл ажиллагаа явуулдаг нь ЛГБТ Төв, Залуус Эрүүл мэнд Төв, Хүний эрх-Залуучууд-Эрүүл мэнд Дэмжих Төв (голдуу дэмжих төв гэдэг), болон Хамтдаа Төв зэрэг юм. Ерөнхийдээ Монголын ЛГБТ хүн амд үйлчилдэг байгууллагуудын чадавхи сул, ихэнхидээ хандивлагчдын санхүүжилтаас хамааралтай, сайн дурынхны дэмжлэгт түшиглэдэг. Дэмжих Төв, Хамтдаа Төв, Залуус Эрүүл мэнд нь гол нь ХДХВ ба ЭБЭ олон нийтийн чиглэлээр ажилладаг, хөдөөд хүрч ажиллах, сургалт явуулах зэрэг үйл ажиллагааг зонхилон явуулдаг. Хамтдаа Төв нь ХДХВ-ийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, ХДХВ/БЗДХ-аас сэргийлэх, хүний эрх ба зан үйлийг өөрчлөх харилцааны сургалтууд явуулдаг. Дэмжих Төв нь хөдөөгийн ЭБЭ-ийн доторхи ХДХВ-ийн урьдчилан сургийлэлт, нийт хүн амын залуучуудад хандсан эрүүл мэнд, ЛГБТ эрхийн асуудлуудаар сургалт сурталчилгаа хийдэг. ЛГБТ Төв нь залуучууд ба трансжендер хөтөлбөрөөсөө гадна хууль эрхийн асуудлаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг ба эрүүл мэнд ба хөдөөд хүрч үйлчлэх хөтөлбөрийг боловсруулаад байгаа. Залуус ба Эрүүл мэнд тус улс дахь цорын ганц ЛГБТ хүмүүст зориулсан олон нийтийн төвийг ажиллуулдаг ба СДЗШ-д зуучлах ба олон нийтэд түшиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулдаг.

Монголын ЛГБТ байгууллагууд Нээлттэй нийгэм форум, Хүний эрх ба хөгжил төв, Глоб Интернэйшнл, Монфемнет – эмэгтэйчүүдийн ТББ-уудын үндэсний сүлжээ, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв зэрэг байгууллагатай амжилттай хамтран ажиллаж байна. ТББ-уудаас биеийн тамирын өдөрлөг, гей үдэшлэг, тэмцээн, ууланд авирах, аялал хийх зэрэг олон нийтийн арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг байна.

## Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл: аюулгүй орон зай, эрүүл мэндийн үйлчилгээ, хүрч үйлчлэх

Монголын ЛГБТ ТББ-ууд хэд хэдэн гол чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. ЛГБТ олон нийт цугларах аюулгүй орчин бий болгох нь тэдний эн тэргүүний зорилтын нэг юм. 2013 онд Залуус эрүүл мэнд болон Хамтдаа төв Европын Холбооны Ардчилал ба Хүний эрхийн санаачлагаас олгосон буцалтгүй тусламжаар ЛГБТ олон нийтэд зориулсан олон нийтийн төвийг байгуулсан. Энэ төв нь хамгаалал хэрэгтэй болсон ЛГБТ хүмүүсийг хүлээн авч, түр хамгаалах байраар үйлчилдэг. Байр нь жижиг, олон хүн байлгах боломжгүй, цахилгаан зуух, ор, ширээ, сандал гэх мэт наад захын хэрэгцээний тавилга, хэрэгсэлтэй. Энэ бол Монголд бий болсон ийм төрлийн анхны үйлчилгээ бөгөөд ЛГБТ хүмүүсийг хүлээн авах ганц аюулгүй байр юм. Энэ төвд сард дунджаар арав орчим хүн хандаж үйлчилгээ авдаг байна. Сэтгэл амар байж болдог болохоор төвийн үйл ажиллагаанд олон нийт ам сайтай байдаг байна. Зохион байгуулагчид нь санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг шийдэж, төвөө өргөжүүлэхийг зорьж байна.

Үйл ажиллагааны хоёр дахь гол чиглэл нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах асуудал юм. Дээр өгүүлсэнчлэн, олон ЛГБТ хүмүүс эрүүл мэндийн тусламж авахдаа гадуурхагдах, эсвэл эрүүл мэндийн тусламж авахаас айж эмээх явдал гардаг. Ихэнх нь тусламж үйлчилгээг ТББ-аар дамжуулан авах нь эрсдэлгүй гэж үздэг. Иймээс ТББ-уудын тусламж үзүүлэгчдийг үндэсний хяналт үнэлгээний тогтолцоонд холбохын тулд Глобал сангаас ЭБЭ гэх мэт гол хүн амд тусгай кодыг хэрэглэн мэдээллийг нэгтгэх тогтолцоог нэвтрүүлжээ (ЭМЯ, 2014). Эдгээр төвөөс ЛГБТ олон нийт зан үйлийн харилцаа, сайн дурын зөвлөгөө, шинжилгээ (СДЗШ), бэлгэвч, хувийн асуудал ба нүүцлалыг хадгалсан үйлчилгээг авах боломжтой.

Монголын ЛГБТ ТББ-уудын үйл ажиллагааны гурав дахь гол чиглэл нь тусламж үзүүлэгч мэргэжлийн хүмүүс, төрийн байгууллагын ажилтнуудын ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа юм. Энэ хүрээнд ТББ, эрүүл мэндийн ажилтнууд, олон нийт, хууль сахиулахын болон хуулийн мэргэжилтэн, хэвлэл мэдээллийнхэн зэрэг янз бүрийн зорилтот бүлэгт сургалт, сурталчилгаа хийдэг. Энэ ажлаар дамжуулан ТББ-ууд бэлгийн цөөнх өөрсдийн санал бодлыг бусадтай хуваалцах, тэднийг гутаан доромжлох хийгээд дорд үзэх нийгмийн үзэл хандлагыг халахын төлөө ажилладаг юм. Хуульч, эмч мэргэжилтнүүдийг оролцуулан ЛГБТ хүмүүс, тэдний гэр бүлийнхэнтэй сар бүр уулзалт хийж, хүний эрхийн асуудлаар бүлгийн ярилцлага хийдэг. 2013 оны Дэлхийн ДОХ-ын өдөр хэвлэлийн бага хурал хийж, бэлгийн болон хүйсийн цөөнхийн хүний эрхийн асуудлыг дэмжихэд хамтран ажилласан хэвлэл мэдээллийн байгууллагуудад Бахархал шагналыг гардуулсан. Мөн ЛГБТ Төвөөс цагдаа болон нийгмийн салбарынхны дунд ЛГБТ хүмүүсийн эрхийн асуудлаар ойлголт нэмэгдүүлэх ажил хийхийн зэрэгцээ Хүний эрхийн түгээмэл тогтмол хяналт болон олон улсын хүний эрхийн бусад механизмаас гаргасан зөвлөмжийг биелүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажил хийдэг.

## ЛГБТ иргэний нийгмийн байгууллагуудын санхүүжилтийн бэрхшээл

Монгол дахь ЛГБТ ТББ-уудын санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал, үндсэндээ олон улсын хандив тусламж, бусад жижиг эх үүсвэрээс санхүүждэг. Олон улсын хандивлагчдын санхүүгийн дэмжлэг нь ЛГБТ байгууллагууд үндэсний, бүсийн болон олон улсын сүлжээнд нэгдэх, үйл ажиллагаа явуулахад ихээхэн дэм болж ирсэн. Гэвч олон улсын санхүүгийн эх үүсвэр тэр бүр олддоггүй, ихэнхдээ тодорхой төслийн ажлыг санхүүжүүлэхээс байгууллагын дотоод үйл ажиллагаанд зарцуулагддаггүй, юунд ашиглах талаар нарийн хязгаартай байдаг. Ихэнх санхүүжилт мөн зөвхөн ХДХВ-ын эсрэг ажилд ашиглах зориулалттай олгогддог. Ийнхүү одоогоор ЛГБТ байгууллагуудын авч буй санхүүжилт нь урт хугацаанд тогтвортой бус байгаа ба өөр бусад хувилбар тун хязгаарлагдмал байна. Монгол дахь ЛГБТ байгууллагуудад төр, хувийн салбараас санхүүжилт олгодоггүй. Энэ нь ЛГБТ үйлчилгээ ба эрхийн холбогдолтой үйл ажиллагааг цаашид



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч Сезин Синаноглу үг хэлэв.

хадгалж үргэлжлүүлэхийн тулд олон улсын санхүүгийн дэмжлэг хэрэгтэй хэвээр байна гэсэн үг юм. Сүүлийн хэдэн жилд ДОХ ба Сүрьеэ өвчинтэй тэмцэх Глобал санхүүгийн гол эх үүсвэр байсан бөгөөд энэ нь хэдий талархууштай боловч уг санхүүжилтээс хамааралтай болоод байна. 2014 онд нэг ТББ гурван хандивлагчаас санхүүжилт авдаг, нэг төсөл батлагдаагүй байгаа гэж тайлагнасан ба Глобал санхүүгийн том санхүүжүүлэгч нь буюу тус ТББ-ын санхүүжилтийн 77 хувийг олгодог байна. Өөр нэг ТББ хоёр хандивлагчаас санхүүжилт авдаг, нэг төсөл батлагдаагүй байгаа гэж тайлагнасны дотор мөн Глобал санхүүгийн гол байр эзэлж байна (2014 оны санхүүжилтийн 78 хувь). Гурав дахь ТББ хоёр хандивлагчаас санхүүжилт авдаг, нэг төсөл нь батлагдаагүй, санхүүжилтийнхээ 96 хувийг Глобал сангаас авчээ. Хоёр байгууллага хэрэв Глобал сангийн санхүүжилт үргэлжлэхгүй бол үйл ажиллагаагаа зогсооход хүрнэ гэжээ. ЛГБТ Төв транжэндэр олон нийтийн чадавхийг дээшлүүлэх жижиг төсөлдөө бага хэмжээний санхүүжилт авсан. Залуус Эрүүл мэнд НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөртэй хамтран бэлгийн цөөнхийн эрхийг сайжруулах төсөлд Европын холбооны 2012-2014 оны хөтөлбөрөөс буцалтгүй тусламж авчээ.

Монгол улсад татварын орлогоос ашгийн бус салбарт хуваарилах гэх мэт арга замаар ТББ-д санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх эрх зүйн үндэс хараахан бүрдээгүй байна. Төрийн бус байгуулланы тухай хуулийг шинэчлэхэд иймэрхүү заалт оруулахаар ТББ-ууд хөөцөлдөж байгаа ч нэмэлт өөрчлөлт оруулах ажил удаашралтай байна.

Санхүүжилт хангалтгүй байгаа нь байгууллагын чадавхид олон талаар нөлөөлж байна. ТББ-ууд ажилтнууддаа өрсөлдөхүйц цалин өгч, тогтвортой ажиллуулж чаддаггүйгээс байгууллага бэхжүүлэхэд хүндрэл учирдаг. Тухайлбал, төлөвлөлт, хөрөнгө босгох, түншлэл, нөлөөллийн чадавхиа бэхжүүлэх гэх мэт стратеги ач холбогдолтой чиглэлээр байгууллага бэхжүүлэхэд хэцүү байдаг. Зөвхөн ЛГБТ Төв жил жилээр олгогддог санхүүгийн үндсэн эх үүсвэртэй бөгөөд үүнийг цалин, байрны түрээс, холбоо харилцааны үрсгал зардалд зарцуулдаг. Бусад байгууллагын хувьд үрсгал зардлаа хэд хэдэн төслөөс хувааж гаргадаг ба энэ нь санхүүгийн менежментэд ч хүндрэлтэй байдаг.





# АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## Монгол хэл дээр

Монгол Улсын Үндсэн хууль (1992)  
Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль (1999)  
Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999)  
Монгол Улсын Эрүүгийн хууль (2002)  
Монгол Улсын Хүний эрхийн хангах үндэсний хөтөлбөр (2003)  
Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хууль (2009)  
Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн төсөл (2014)  
Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн төсөл (2014)  
Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн төсөл (2014)  
Монгол Улсын Гэмт хэргийн тухай хуулийн төсөл (2014)  
Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны тогтоол No 13 (2013)

И.Лей, Н.Доржханд, Д.Алтанчимэг, Х. Энхжаргал. (2014). *Монгол дахь бэлгийн цөөнхийн талаар хууль эрх зүйн болон бодлогын орчинд хийсэн баримтын судалгаа*. Улаанбаатар ЛГБТ Төв. (2012). *Монгол дахь бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт*. (хэвлэгдээгүй).  
Эрүүл мэндийн яам. (2008). *Эрүүл мэндийн боловсролын стандарт*. Улаанбаатар, ЭМЯ.  
ЭМЯ, ДЭМБ. (2014). *ХДХВ/БЗДХ-ын тархалтын үнэлгээ ба үр нөлөөний шинжилгээ (төсөл)*.  
Улаанбаатар: ЭМЯ, ДЭМБ.

Хууль зүй, дотоод хэргийн яам. (2011). *Хүний эрхийн хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц: хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан*. [www.moj.gov.mn](http://www.moj.gov.mn)

Хэвлэлийн хүрээлэн (2013). *Монголын хэвлэл мэдээлэл- өнөөдөр*. Хэвлэлийн хүрээлэн. Улаанбаатар.

Хүний эрхийн үндэсний комисс (2013). *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэл*, Улаанбаатар.

ДҮХ, НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөр, Жон Хопкинс Нийгмийн эрүүл мэндийн сургууль. (2012). *Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн (ЭБЭ) ХДХВ-ын эрсдэлт байдал, тусламж үйлчилгээний хүртээмж, хүний эрхийн нөхцөл байдалд хийсэн үнэлгээ*. Улаанбаатар.

Үндэсний статистикийн хороо (ҮСХ). (2010). *2010 оны Хүн ам, орон сууцны тооллогын дүн*, Улаанбаатар.

Үндэсний статистикийн хороо (ҮСХ). (2013). *Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2013*, Улаанбаатар.

Shuum.mn. (2013). *Монголын сайтуудын сэтгэгдэл дээр бичих хориотой үгсийн жагсаалт*. 2013 оны 3 дугаар сарын 15.

## Англи хэл дээр

Burns, C. (2011). Fact Sheet: LGBT Discrimination in Higher Education Financial Aid. Center for American Progress. Retrieved 20 August 2013, from [http://www.americanprogress.org/wp-content/uploads/issues/2011/08/pdf/lgbt\\_factsheet.pdf](http://www.americanprogress.org/wp-content/uploads/issues/2011/08/pdf/lgbt_factsheet.pdf).

Freedom House. (2006). *Freedom in the World 2006*. Retrieved 1 August 2014, from Freedom House: <http://www.freedomhouse.org/report/freedom-world/freedom-world-2006#.VCAvai6Sz40>

Gardner, L. (2014a). *Mongolia's Media Laws Threaten Press Freedom*. Retrieved 1 April 2014, from PBS: <http://www.pbs.org/idealab/2014/04/mongolias-media-laws-threaten-press-freedom/>

- Gardner, L. (2014b). *Mongolia plans anti-discrimination laws*. 22 June 2014. Retrieved July 7, 2014, from AlJazeera: <http://www.aljazeera.com/indepth/features/2014/06/mongolia-plans-anti-discrimination-laws-2014617101854814248.html>
- Global Fund (Country Coordinating Mechanism Mongolia). (2014). *Global Fund Concept Note: HIV Component*.
- Grant, J. M., Mottet, L. A., Tanis, J. et al. (2011). *Injustice at Every Turn: A Report of the National Transgender Discrimination Survey*. Washington: National Center for Transgender Equality and National Gay and Lesbian Task Force. Retrieved 20 August 2013 from [www.thetaskforce.org/downloads/reports/reports/ntds\\_full.pdf](http://www.thetaskforce.org/downloads/reports/reports/ntds_full.pdf)
- Harvey, G., & Wallis, R. J. (2007). *Historical Dictionary of Shamansim*. Scarecrow Press, Inc.
- International Commission of Jurists & the International Service for Human Rights. (2007). *Yogyakarta Principles on the Application of International Human Rights Law in relation to Sexual Orientation and Gender Identity*. Retrieved 1 April 2014, from Yogyakarta Principles: [http://www.yogyakartaprinciples.org/principles\\_en.pdf](http://www.yogyakartaprinciples.org/principles_en.pdf)
- Itaborahy, L. P., & Zhu, J. (2013). *State-Sponsored: Homophobia A World Survey o Laws: Criminalisation, Protection and Recognition of Same-Sex Love*. ILGA.
- LGBT Centre & the Sexual Rights Initiative. (2010). *Report on Mongolia: Ninth Session of the Universal Periodic Review*. Ulaanbaatar: LGBT Centre.
- MOH, WHO. (2012). *Health Service Delivery Profile: Mongolia 2012*. Retrieved 1 April 2014, from WHO Mongolia: [http://www.wpro.who.int/health\\_services/service\\_delivery\\_profile\\_mongolia.pdf](http://www.wpro.who.int/health_services/service_delivery_profile_mongolia.pdf)
- Nyamdorj, A. (2010). Ultra-Nationalism in Mongolia and the LGBT Community. *Asian Human Rights Defender*, 17-18.
- Nyamdorj, A., & Garner, R. (2008). The Status of Lesbian and Bisexual Women and Transgendered Persons in Mongolia. Shadow report for the 42nd CEDAW Committee Session. Ulaanbaatar.
- OHCHR. (2011a). *Consideration of reports submitted by States parties under article 40 of the Covenant*. Retrieved 1 September, 2014 from: <http://daccess-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G11/425/77/PDF/G1142577.pdf?OpenElement>
- OHCHR. (2011b). *Discriminatory Laws and Practices and Acts of Violence against Individuals Based on their Sexual Orientation and Gender Identity*. 17 November 2011. Retrieved 27 August 2013, from: [http://www.ohchr.org/Documents/HRBodies/HRCouncil/RegularSession/Session19/A-HRC-19-41\\_en.pdf](http://www.ohchr.org/Documents/HRBodies/HRCouncil/RegularSession/Session19/A-HRC-19-41_en.pdf).
- Peitzmeier, S. M., Yasin, F., Wirtz, A., Delegchoimbol, A., & Baral, S. (2014). *Sexual Violence Against Men who have Sex with Men in Mongolia: The Scope and Consequences*.
- Population Council. (2002). *Universal Sexuality Education in Mongolia: Educating Today to Protect Tomorrow*. New York.
- Sears, B. & Mallory, C. (2011). *Documented Evidence of Employment Discrimination and Its Effects on LGBT People*. The Williams Institute. Retrieved 30 August 2013 from <http://williamsinstitute.law.ucla.edu/wp-content/uploads/Sears-Mallory-Discrimination-July-2011.pdf>
- Strömdahl. (2013). *Human rights violations as a barrier to implementing HIV prevention programs for key populations: The Case of Men Who Have Sex With Men (MSM) in Ulaanbaatar, Mongolia*.
- Tufnell, N. (2014). 'Assgoblin', 'pooface' and 'douchewaffle': all banned in Mongolia. 20 March 2014. Retrieved 1 April 2014, from Wired.co.uk: <http://www.wired.co.uk/news/archive/2014-03/20/banned-mongolian-words>
- Ts. Otgonbaatar, G. Nyampurev, A. Bulbul, D. Munkhasan. (2014). *LGBT Poverty Study*. Ulaanbaatar.
- Ts. Otgonbaatar. (2013) Mongolia Pride Week, 26 November 2013. UNAIDS Mongolia
- UN Committee Against Torture. (2010). *Concluding observations of the Committee Against Torture, Mongolia*.
- UN HRC. (2009). *Report of the Special Rapporteur on the right to education, Vernor Muñoz Villalobos, Mission to Mongolia*. UN General Assembly.
- UN HRC. (2011). *Report of the Working Group on the Universal Periodic Review, Mongolia*. UN General Assembly.
- UN HRC. (2013). *Report of the Special Rapporteur on extreme poverty and human rights, Magdalena Sepúlveda Carmona, Mission to Mongolia*. UN General Assembly.
- UNAIDS (2013). *Global report: UNAIDS report on the global AIDS epidemic 2013*. Geneva: UNAIDS.



- 
- UNICEF. (2013). *At a glance: Mongolia*. 27 December 2013. Retrieved July 9, 2014, from UNICEF: [http://www.unicef.org/infobycountry/mongolia\\_statistics.html](http://www.unicef.org/infobycountry/mongolia_statistics.html)
- USAID. (n.d.) LGBT Global Development Partnership: Promoting Lesbian, Gay, Bisexual, and Transgender Inclusive Development. Retrieved 20 August 2013 from <http://www.usaid.gov/sites/default/files/documents/2496/USAID%20Fact%20Sheet%20LGBT%20Global%20Partnership.pdf>
- Winter, C. (2012) Responding to LGBT Health Disparities. Ryan Barker & Thomas McAuliffe (Eds.). Missouri Foundation for Health. Retrieved 23 August 2012 from <http://www.mffh.org/mm/files/LGBTHealthEquityReport.pdf>
- Youth Voices Count. (2013). *Self-stigma Among Young MSM and Youth Transgender Women and Linkages with HIV in Asia*. Bangkok.



## ХАВСРАЛТ 1: МОНГОЛ ДАХ ЛГБТ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

Байгууллагын нэр	Холбоо барих хүн	Утас (+976)	Э-майл хаяг	Шуудангийн хаяг
ЛГБТ Төв	Анараа Нямдорж	70110323, 95505907	anaraa@lgbtcentre.mn	ЛГБТ Төв, Төв шуудан, ШХ 120, Улаанбаатар-13, Монгол Улс
Залуу Эрүүл Мэнд Төв	Мягмардорж Доржготов	11320702, 99040735	Zaluus_eruulmend@yahoo.com	Залуус Эрүүл Мэнд Төв, Баянзүрх дүүрэг, 15-р хороолол, 29-р байр, 47 тоот Улаанбаатар, Монгол Улс
Хүний эрх-Залуус-Эрүүл мэнд-Дэмжих Төв (Дэмжих төв)	Батзориг Хашбат	70100135, 88037077	demjih_tuv@yahoo.com	Хүний эрх-Залуус-Эрүүл мэнд-Дэмжих Төв, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 8-р байр, 1-р орц, 00 тоот Улаанбаатар, Монгол Улс
Хамтдаа Төв	Эрдэнэтуяа Гомбо	11450783, 99819496	g.erdenetuya@yahoo.com	Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Erinline ХХК, 1-р орц, өрөө 107 Улаанбаатар, Монгол Улс

## ХАВСРАЛТ 2: МОНГОЛЫН ЛГБТ ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

### **Төрийн байгууллагууд**

УИХ-ын Хууль зүйн Байнгын хороо  
Хүний эрхийн үндэсний комисс  
Төрийн албаны зөвлөл  
Шүүхийн ерөнхий зөвлөл

Уул уурхайн яам  
Хууль зүйн яам  
Хөдөлмөрийн яам  
Эрүүл мэндийн яам  
Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яам  
Соёл, спорт, аялал жуучлалын яам

Хууль зүйн яамны Эрх зүйн туслалцааны төв  
Цагдаагийн ерөнхий газар  
Хууль зүйн үндэсний хүрээлэн  
Хүүхдийн төлөө үндэсний газар  
Нийгмийн халамжийн үндэсний газар  
Боловсрол, шинжлэх ухааны яамны  
Боловсролын хүрээлэн  
Жендэрийн үндэсний хороо  
Халдварт өвчин судлалын үндэсний төв

### **ТББ**

ЛГБТ төв  
Залуус Эрүүл мэнд төв  
Дэмжих төв  
Хамтдаа төв  
Шинэ өөдрөг амьдрал Төв  
Монголын Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг  
Монголын Залуучуудын холбоо  
Хэвлэлийн хүрээлэн/ Сэтгүүл зүйн сургууль  
Өглөөний мэдээ  
Бутайн оргил ТББ  
Хүчирхийллийн эсрэг үндэсний төв  
Монголын хуульчдын холбоо  
Монголын ажил эрхлэгчдийн холбоо  
Монголын сэтгэл зүйн төв  
Энх тайвны корпус  
Амнести Интернэйшнл  
World Smile

### **Элчин сайдын яамд, олон улсын байгууллагууд**

Монгол дахь АНУ-ын Элчин сайдын яам  
АНУ-ын ОУХА, Монгол дахь АНУ-ын ОУХА  
Швецарийн Хөгжлийн агентлаг (SDC)  
Чехийн Элчин сайдын яам  
Канадын Элчин сайдын яам  
Францын Элчин сайдын яам  
НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөр  
НҮБ-ын Хүүхдийн сан  
Олон улсын хөдөлмөрийн байгууллага  
НҮБ-ын Хүн амын сан  
НҮБ-ын Залуучуудын зөвлөх хороо (UNYAP)  
НҮБХХ

### **Их дээд сургууль, судалгааны байгууллага Монголын Улсын их сургууль**

### **Хэвлэл мэдээлэл**

Монголын үндэсний олон нийтийн радио,  
телевиз  
VIP ‘Онцгой чухал хүн’  
Оюуны дархлаа  
‘UB Post’  
Үндэсний шуудан



*Empowered lives.  
Resilient nations.*

**United Nations Development Programme**  
**UNDP Asia-Pacific Regional Centre**  
Regional Centre United Nations Service Building,  
3rd Floor Rajdamnern Nok Avenue, Bangkok 10200, Thailand  
Email: [aprc.th@undp.org](mailto:aprc.th@undp.org)  
Tel: +66 (0)2 304-9100  
Fax: +66 (0)2 280-2700  
Web: <http://asia-pacific.undp.org/>